

Ерөнхий Нөхцөл

ГАРЧИГ

1. **Нэр томъёоны тодорхойлолт, тайлбар**
 - 1.1 Нэр томъёоны тодорхойлолт
 - 1.2 Тайлбар
2. **Гэрээний нотлох баримт, баримт бичгийг давууд үзэх дараалал**
 - 2.1 Гэрээ
 - 2.2 Гэрээний баримт бичгийг давууд үзэх дараалал
 - 2.3 Гэрээний бүрэн бүтэн байдал
 - 2.4 Бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах
3. **Мэдээллийн үнэн зөв байдал**
 - 3.1 Компаниас мэдэгдэл өгөхгүй
 - 3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь үнэн зөв байдалд ханамжтай байх
 - 3.3 Үүргээс чөлөөлөхгүй байх
 - 3.4 Компани хариуцлага хүлээхгүй байх
4. **Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний гүйцэтгэл**
 - 4.1 Гүйцэтгэл
 - 4.2 Илгээх бараа
5. **Үйлчилгээ үзүүлэгчийн баталгаа**
 - 5.1 Үйлчилгээ үзүүлэгчийн баталгаа
 - 5.2 Худалдааны баталгааны хуулбар хувь
6. **Доголдол, зөрчил дутагдлыг арилгах**
 - 6.1 Доголдолтой үйлчилгээг засах
 - 6.2 Баталгаа
 - 6.3 Баталгаат хугацаа эхлэх
 - 6.4 Зөрчил, дутагдлыг арилгах
 - 6.5 Үйлчилгээ үзүүлэгч зөрчил, дутагдлыг арилгахгүй байх
7. **Хугацаа**
8. **Төлөөлөл**
 - 8.1 Гэрээний гүйцэтгэл
 - 8.2 Компанийн төлөөлөгч
 - 8.3 Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгч
9. **Хүргэлт, өмчлөх эрх, эрсдэл**
 - 9.1 Хүргэлт
 - 9.2 Өмчлөх эрх
 - 9.3 Эрсдэл
10. **Гэрээний үнэ**
 - 10.1 Гэрээний үнэ
 - 10.2 Гэрээний үнэд багтах зардал
11. **Татвар,**
 - 11.1 Татвар, Шууд бус гүйлгээний татвар, Суутгах татвар – Гадаадын үйлчилгээ үзүүлэгч
 - 11.2 Татвар, шууд бус гүйлгээний татвар, суутгах татвар – Дотоодын монгол үйлчилгээ үзүүлэгч
12. **Гаалийн ба онцгой албан татвар**
13. **Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөр**
 - 13.1 Төлбөрийн хэлбэр
 - 13.2 Худалдааны нэхэмжлэх
 - 13.3 Худалдааны нэхэмжлэхийн төлбөр
 - 13.4 Маргаан бүхий худалдааны нэхэмжлэх
 - 13.5 Нэхэмжлэхийн алдаа ба онцгой тохиолдол
14. **Төлбөрийн суутгал**
 - 14.1 Суутгал тооцох
 - 14.2 Хуулийн дагуух суутгал, хасалт
 - 14.3 Суутгал, хасалт тооцох тухай мэдэгдэх
15. **Худалдан авалтын доод хэмжээ байхгүй ба онцгой эрх олгохгүй байх**
 - 15.1 Худалдан авалтын доод хэмжээ байхгүй байх
 - 15.2 Онцгой эрх олгохгүй байх
16. **Үйлчилгээ үзүүлэгчийн ажиллах хүч**
 - 16.1 Үйлчилгээ үзүүлэгчийн ажиллах хүч
 - 16.2 Ажиллах хүчний тохиролцоо
 - 16.3 Компани ажилтнуудаас татгалзах
 - 16.4 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага
17. **Бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, ачилт, тээвэрлэлт**
 - 17.1 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага
 - 17.2 Тээвэрлэлтийг Компани хариуцах
 - 17.3 Тээвэрлэлтийн бэлтгэл
 - 17.4 Илгээсэн/ачсан өдрийг мэдэгдэх
18. **Хяналт шалгалт**
 - 18.1 Хяналт шалгалт
 - 18.2 Мэдээллээр хангах үүрэг
 - 18.3 Хяналт шалгалтын зардал
19. **Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг**
 - 19.1 Заалтын хэрэглээ
 - 19.2 Үйлчилгээ үзүүлэгч баталгаа гаргах
 - 19.3 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутагтай холбоотой хууль тогтоомж, бодлого шийдвэр, холбогдох стандартыг дагаж мөрдөх
 - 19.4 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутгийн удирдлагын төлөвлөгөө
 - 19.5 Танилцуулах сургалт
 - 19.6 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага
20. **Үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэлд аудит хийх эрх**
 - 20.1 Аудит
 - 20.2 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс авах арга хэмжээ
21. **Сайтад нэвтрэн орох**
 - 21.1 Нэвтрэх эрх
 - 21.2 Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг
 - 21.3 Сайтад Нэвтрэх эрх олгохоос татгалзах эрх ба Сайтаас гаргах
 - 21.4 Эзэмших онцгой эрх байхгүй байх
22. **Компанийн бодлогод нийцүүлэх**
 - 22.1 “Оюу толгой” ХХК-ийн бодлого
 - 22.2 Рио Тинтогийн бизнесийн үйл ажиллагааны туршлага, стандартууд

- 23. Хууль**
 23.1 Хууль тогтоомжид нийцүүлэх
 23.2 Хууль зөрчсөнөөс үүсэх үр дагавар
- 24. Давагдашгүй хүчин зүйлс**
 24.1 Давагдашгүй хүчин зүйлсийг мэдэгдэх
 24.2 Давагдашгүй хүчин зүйлс бий болсон тухай мэдэгдэл
 24.3 Хохирлыг арилгах, засч залруулах үүрэг
- 25. Даатгал**
 25.1 Үйлчилгээ үзүүлэгчийн даатгалууд
 25.2 Ерөнхий болон бүтээгдэхүүний хариуцлагын даатгал
 25.3 Ажилчдын нөхөн олговор ба ажил олгогчийн хариуцлагын даатгал
 25.4 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмж
 25.5 Тээвэрлэлтэнд яваа бараа
 25.6 Автомашины/тээврийн хэрэгслийн гуравдагч талын хариуцлагын даатгал
 25.7 Мэргэжлийн хариуцлагын даатгал
 25.8 Даатгалын нөхцлүүд
 25.9 Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний дагуух мэдэгдэл
 25.10 Туслан гүйцэтгэгчдийн даатгал
 25.11 Даатгалын нөхөн олговрын нэхэмжлэх ба нөхөн олговрын зөрүүг төлөх
- 26. Нөхөн төлбөр**
 26.1 Хүлээн зөвшөөрөх
 26.2 Нөхөн төлбөр
 26.3 Онцгой тохиолдол
 26.4 Нөхөн төлбөрийн эрх эдлэхээс өмнө зардал гаргахгүй байх
- 27. Зөрчил гараагүй үед Гэрээ цуцлах**
 27.1 Гэрээ цуцлах тухай мэдэгдэл
 27.2 Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авсанаар хүлээх үүрэг
 27.3 Гэрээх цуцлах үед хүлээх үүрэг
 27.4 Үйлчилгээ үзүүлэгчид нөхөн төлбөр олгох
- 28. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчих**
 28.1 Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл
 28.2 Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд тавигдах шаардлага
 28.3 Гэрээг цуцлах үед хүлээх үүрэг
 28.4 Хохиролгүй болгох
- 29. Маргаан шийдвэрлэх**
 29.1 Маргаан
 29.2 Талуудын маргаан шийдвэрлэх төлөөлөгчид
 29.3 Маргаан үүссэн үе дэх гэрээний үүргийн гүйцэтгэл
 29.4 Яаралтай үед түр зуурын арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 30. Нууцлал**
 30.1 Нууцлалыг хангах үүрэг
 30.2 Онцгой тохиолдол
 30.3 Зөвшөөрлийг зөрчих
 30.4 Үйлчилгээ үзүүлэгч хүлээн зөвшөөрөх
 30.5 Нөхөн төлбөр
 30.6 Нэмэлт хариуцлага
 30.7 Нууц мэдээллийг буцаах
- 31. Нийтэд зарлан мэдээлэх**
- 32. Оюуны өмчийн эрх**
 32.1 Үйлчилгээ үзүүлэгчийн оюуны өмч
 32.2 Гуравдагч талын Оюуны Өмчийн Эрх
 32.3 Нөхөн төлбөр
 32.4 Оюуны Өмчийн Эрхийн Худалдан авах ажиллагаа
 32.5 Оюуны өмчийн эрх худалдан авах боломжгүй үеийн журам
- 33. Мэдэгдэл**
 33.1 Мэдэгдлийн хэлбэр
 33.2 Мэдэгдлийг хүлээн авсан гэж үзэх
- 34. Зардал**
 34.1 Талууд өөрсдийн зардлыг хариуцах
 34.2 Тэмдэгтийн хураамж
- 35. Үйлчилгээ үзүүлэгчийн статус**
 35.1 Хараат бус гүйцэтгэгч
 35.2 Түншлэл, хамтарсан нийлүүлэгч
- 36. Эрх, үүргээ шилжүүлэх болон Туслан гүйцэтгүүлэх**
 36.1 Компани зөвшөөрөл олгох
 36.2 Туслан гүйцэтгүүлэх эсвэл эрх үүрэг шилжүүлэхэд хүчинтэй байх үүрэг
 36.3 Туслан гүйцэтгэгчийн статус
- 37. Хувийн нууцлал ба мэдээлэл хамгаалал**
 37.1 Хувийн мэдээллийн хамгаалах
 37.2 Баталгаа
 37.3 Мэдээллийн хамгаалалт
 37.4 Хувь хүний гаргасан гомдол
 37.5 Үйлчилгээ үзүүлэгчийн нөхөн төлбөр
- 38. Эрхээсээ татгалзах**
- 39. Нэмэлт баталгаа**
- 40. Гэрээний тусгаар байдал**
 40.1 Гэрээний тусгаар байдал
 40.2 Сайн санаагаар хэлэлцээ хийх
- 41. Удирдлага болгох хууль**
 41.1 Удирдлага болгох хууль
 41.2 НҮБ-ийн конвенц – Олон улсын бараа худалдах, худалдан авах
 41.3 Гуравдагч талын эрх
- 42. Гэрээний нөхцөлийн хүчинтэй байдал**
- 43. Гэрээний хэл**

1. Нэр томъёоны тодорхойлолт, тайлбар

1.1 Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү гэрээ болон ерөнхий нөхцөлд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

Нэхэмжлэх хүлээн авах хугацаа гэж хуанлийн сарын эхний өдөр эхлээд тухайн хуанлийн сарын сүүлийн өдрөөр дуусч буй хугацааг хэлнэ.

Холбогдох бараа бүтээгдэхүүн гэж Худалдан авах захиалгад тусгасан Үйлчилгээ үзүүлэгчийн ханган нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг (хэрэв байгаа бол) хэлнэ.

Салбар компани гэж гэрээний нэг тал нь хяналтыг хэрэгжүүлж буй эсхүл түүний хяналт дор буй эсхүл нэгдсэн хяналт дор буй аливаа корпораци, компани, нөхөрлөл, хязгаарлагдмал нөхөрлөл, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хамтарсан хөрөнгө оруулалттай компани ба аж ахуйн нэгжийн бусад хэлбэрийг ойлгоно. “Хянах” гэсэн үгийг үйл үгээр хэрэглэх бол тухайн хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэх, эсхүл удирдлагын бодлого чиглэлд нөлөө үзүүлэх, чиглүүлэхдээ (i) саналын эрхтэй хувьцааны эсвэл гишүүнчлэлийн ашиг сонирхлын хууль ёсны өмчлөгч болон; (ii) менежер, захирал болон корпорацийн удирдлагыг томилох эрх; (iii) гэрээ; (iv) үйл ажиллагааны гэрээ, хэлцэл; (v) санал өгөх итгэмжлэлээр эсвэл өөр аргаар нэг буюу түүнээс дээш тооны зуучлагчаар шууд, шууд бусаар хэрэгжүүлэх эрх мэдэл; эсвэл хэрэв аливаа этгээдэд хамаарч хэрэглэгдэж байвал тухайн этгээдийн үйл ажиллагааг хянах бодит, хууль ёсны эрх мэдлийг; хэрэв нэр үгээр хэрэглэх бол дээр дурдсан эрх мэдлийн алийг ч хэрэгжүүлэх эрхийг холбогдох этгээдэд олгож буй ашиг сонирхлыг хэлнэ.

Холбогдох хууль гэж энэхүү гэрээний дагуу аль нэг талын эрх, үүрэгтэй холбоотой эсвэл тухайн нийлүүлэлт хийгдэх, түүнийг ашиглах газрын эрх зүйн тогтолцооноос хамаарах орон нутаг, улс, муж, нутаг дэвсгэр, үндэсний болон холбооны аливаа хууль, тогтоомж, дүрэм, журам, гэрээ хэлэлцээр, Засгийн газрын агентлагийн тушаал шийдвэрийг хэлнэ.

Ажлын өдөр гэж гэрээний үүргийг биелүүлэх газар эсхүл 33-т заасан мэдэгдэл хүргэгдэх газарт орших банкны Бямба, Ням гараг болон нийтээр амрах баярын өдрүүдээс бусад ажиллах өдрийг хэлнэ.

Цуцлах өдөр гэдгийг 28.2(b)(iii)-д тодорхойлов.

Нэхэмжлэл гэж аливаа хэлбэрийн нэхэмжлэл, зарга, хэрэг эсвэл хүсэлт шаардлагыг хэлнэ. (Компани, түүний ажилтан, Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтан, аливаа гуравдагч талаас гаргасан, эсхүл эсрэгээр хэнд нь ч хандсан байж болно)

Худалдааны нэхэмжлэх гэж шууд бус гүйлгээний татварыг төлөх хариуцлагыг ногдуулсан, тогтоосон, нэхэмжилсэн тухайн улс орны холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр маягтын дагуу гаргасан авлага, өрийн бичгээр үл хязгаарлагдах аливаа нэхэмжлэх буюу бусад баримт бичгийг хэлэх бөгөөд уг нэхэмжлэхийг гаргасан хүн нь Орлогын татварын хөнгөлөлт эдлэх эрхтэй байна.

Компани гэдэгт “Оюу толгой” ХХК-г ойлгоно.

Компаниас шаардсан чадвар гэдгийг 19.5(b)-д тодорхойлов.

Компанийн танилцуулах сургалт гэдгийг 19.5.(a)-д тодорхойлов.

Компанийн төлөөлөгч гэдгийг Худалдан авах захиалгад тодорхойлсны дагуу болон дор дурдсанаар ойлгоно. Үүнд:

- (a) Төлөөлөгчийг орлох тухай Компанийн бичгээр баталгаажуулсан бусад этгээд; эсхүл
- (b) Төлөөлөгчийн аливаа эрх, үүрэг хариуцлага, үйл ажиллагааны эрх чөлөө, эрх мэдлийг хэрэгжүүлэхээр тухайн төлөөлөгчийн албан ёсоор зөвшөөрөл олгосон этгээд зэрэг болно.

Компанийн хувийн мэдээлэл гэж Компаниас Гэрээтэй холбоотойгоор тухай бүрт Үйлчилгээ үзүүлэгчид өгсөн хувийн чанартай мэдээллийг ойлгоно.

Нууц мэдээлэл гэдэгт энэхүү Гэрээ, Компани болон Рио Тинто Группийн (тухайн үйлчилгээтэй холбоотой) гишүүдийн бизнес, ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой ,нууц шинж чанар бүхий (Үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилтан тухайн мэдээллийг нууц гэдгийг мэдэх боломжтой байх) (аливаа хэлбэрийн) дараах мэдээлэл, баримт бичгийг ойлгох бөгөөд дор дурдсан мэдээлэл нууц байна. Үүнд:

- (a) Компанийн нэрийн өмнөөс эсхүл түүгээр Үйлчилгээ үзүүлэгч эсвэл түүний ажилтнуудад задруулсан;
- (b) Үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний ажилтан нь үйлчилгээ үзүүлэх явцад бий болгож бүтээсэн; эсхүл
- (c) Үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний ажилтаны өөр бусад байдлаар олж мэдсэн зэрэг болно.

Илгээх бараа гэж Хүргэлтийн цэгт Үйлчилгээ үзүүлэгч хүргэсэн, Үйлчилгээ үзүүлэгчийн мэдэлд байх, 4.2-р заалтын дагуу Компани захиалж болох бараа бүтээгдэхүүнийг хэлнэ.

Гэрээ гэдгийг 2.1-д тодорхойлов.

Гэрээний үнэ гэдгийг 10.1-д тодорхойлов.

Гаалийн татвар гэж бараа материалыг импортлох, экспортлохтой холбоотойгоор төрийн аль нэг байгууллагаас ногдуулсан, нэхэмжилсэн, оногдуулсан, тогтоосон эсхүл тухайн байгууллагад төлбөл зохих аливаа татварыг хэлнэ.

Суутгасан дүн гэдгийг 14.2-д тодорхойлов.

Доголдол арилгах хугацаа гэж (хамаарах бол) Худалдан авах захиалгад заасан хугацааг хэлэх бөгөөд эсхүл Худалдан авах захиалгад ийм хугацаа заагаагүй бол тухайн бараа бүтээгдэхүүнийг Компани хүлээн авсанаас хойшхи 1 жилийн хугацааг хэлнэ .

Хүргэлтийн цэг гэж Худалдан авах захиалгад заасан бараа бүтээгдэхүүнийг хүргэх газрыг хэлнэ .

Маргаан гэдгийг 29.1-д тодорхойлов.

Маргааны тухай мэдэгдэл гэдгийг 29.1-д тодорхойлов.

Талуудын маргаан шийдвэрлэх төлөөлөгчид гэдгийг 29.2(а)-д тодорхойлов.

Баримт бичиг гэж төлөвлөгөө, дизайн, зураг төсөл, тооцоо, инженер техникийн мэдээлэл, өгөгдөл, техникийн тодорхойлолт шаардлагууд, скез, тэмдэглэл, загвар жишээ, тайлан, газрын зураг, бүртгэл тооцоо, үйл ажиллагааны гарын авлага, сургалтын материал болон гэрээнд тодорхойлсон бусад (биет болон цахим хэлбэрээр хадгалсан) баримт бичгүүдийг хэлнэ.

Монголын үндэсний үйлчилгээ үзүүлэгч гэж Монгол улсын аж ахуйн нэгж, хувь хүн бөгөөд Монгол улсын татвар төлөгчөөр бүртгүүлсэн Үйлчилгээ үзүүлэгчийг хэлнэ.

Онцгой албан татвар гэж барааны үйлдвэрлэлтэй холбоотойгоор аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагад төлөх шаардлагатай буюу ногдуулсан, нэхэмжсэн аливаа татварыг хэлнэ.

Барилга байгууламж гэж ажлын талбай дахь аливаа байр, хоол хүнс, тээврийн үйлчилгээ, эмнэлэг, бие засах газрыг хэлнэ.

Давагдашгүй хүчин зүйлс гэж энэ тухай нэхэмжлэх гаргаж буй талын хувьд удирдлага хяналтаас давсан, тухайн этгээд урьдчилан сэргийлж түүнээс зайлсхийх ямар нэгэн арга хэмжээ авч даван туулах боломжгүй буюу урьдчилан харах боломжгүй аливаа үйл явдал эсхүл шалтгааныг хэлэх бөгөөд үүнд (дээр дурдсан нөхцөлд нийцэхүйц) дараахь зүйлс орно. Үүнд:

- (a) байгалийн гамшиг (цаг агаарын онц аюулаас бусад);
- (b) хуй салхи, гал түймэр;үер, эсхүл
- (c) дайн тулаан, Монголын Засгийн газрын агентлагуудын үйл ажиллагаа, дайсны довтолгоо, террорист үйл ажиллагаа, бослого мөргөлдөөн болон олон нийтийн эмх замбараагүй байдал зэрэг болно.

Гадаад үйлчилгээ үзүүлэгч гэж Монгол улсын аж ахуйн нэгж, хувь хүн бөгөөд Монгол улсын татвар төлөгчөөр бүртгүүлээгүй үйлчилгээ үзүүлэгчийг хэлнэ.

Төрийн эрх бүхий байгууллага гэж аливаа Засгийн газар эсхүл түүний харьяаны зохицуулагч, захиргааны, хагас төрийн оролцоот, орон нутгийн/хотын захиргааны, санхүү татвар эсхүл шүүх эрх мэдэл бүхий байгууллага, яам тамгын газар, комиссын бүрэлдэхүүн, нэгж хэлтэс, шүүх, эрх бүхий байгууллагууд, товчоод, төрийн түшмэл, яамдын сайд, улсын мэдлийн корпораци, маргаан шийдвэрлэх комисс болон хууль,журам, дүрэм батлан гаргах бусад эрх бүхий байгууллыг хэлнэ.

ЭМААБООН гэж эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутгийг хэлнэ.

ЭМААБООН-ийн Удирдлагын Төлөвлөгөө гэдгийг 19.4(а)-д тодорхойлов.

ЭМААБООН-ийн бодлого, стандарт гэдгийг 19.3(а)-д тодорхойлов.

Хариуцлагаас чөлөөлөгдөх тал гэж Компани, түүний ажилтныг хэлнэ.

Шууд бус гүйлгээний татвар гэж аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагад төлөхөөр ногдуулсан, нэхэмжилсэн аливаа нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бараа, үйлчилгээний татвар эсхүл түүнтэй төсөөтэй худалдаа, хэрэглээ, ашиглалтын татварыг хамааруулах ба торгууль, шийтгэл, хүүг энд оролцуулахгүй.

Татварын хөнгөлөлт гэж нь аливаа нийлүүлэлтийг худалдан авсан буюу хүлээн авсантай холбоотойгоор тавигдах Шууд бус гүйлгээний татварын хасалт, хөнгөлөлт, зөрүү, буцаан олголт зэрэг хөнгөлөлтийн эрхийг хэлнэ.

Оюуны өмчийн эрх гэж бүхий л зохиогчийн эрх болон түүнтэй төстэй эрхүүдийг багтаасан зохион бүтээх (бүх патентууд болон патентын хүсэлтийг хамааруулах), худалдааны нууцууд ба ноу-хау, зураг төсөлтэй холбоотой эрхүүд(бүртгэж болох эсэх нь хамаагүй), бүртгэсэн бүртгээгүй худалдааны тэмдэг, цахилгаан электроникийн хэлхээний зураг төсөл болон түүнтэй холбоотой эрх, зэрэг нь хуулиар хамгаалагддаг бүх үйлдвэрлэлийн болон оюуны өмчийн эрхийг ойлгоно. Гэхдээ шилжүүлэх боломжгүй ёс суртахууны эрхүүд, эсхүл түүнтэй төстэй шилжүүлэх боломжгүй зохиогч ба үйлдвэрлэгчийн хувийн эрхүүд зэргийг оюуны өмчийн эрхэд хамруулахгүй.

Хамтрагчид гэж хамтран ажиллах зорилгоор уг хамтарсан үйл ажиллагааны нэг тал болж оролцож буй этгээдийг хэлнэ.

Хариуцлага гэдэгт бүх төрлийн хохирол, нэхэмжлэл, алдагдал, зардал зэргийг ойлгоно.

Монголын НӨАТ-ын баримт гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) тухай Монгол улсын хуулинд заасан шаардлагыг хангасан төлбөрийн баримтыг хэлнэ.

Монголын ажлын байрны төлбөр гэж (үйлчилгээ үзүүлэгч эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлслөн ажиллуулж буй) Үйлчилгээний үзүүлж (эсхүл аливаа холбогдох бараа бүтээгдэхүүний хүргэлт) буй Монгол улс дахь гадаад (Монгол хүн бус) ажилтнуудад Ажиллах хүч гадаад гаргах болон гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Монгол Улсын хуулийн дагуу үүний дагуу ажлын байранд ногдуулах төлбөрийг ойлгоно.

Албан тушаалтан гэж:

- (a) Аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагын ажилтан, албан тушаалтан, эсхүл тухайн Засгийн газрын эрх бүхий байгууллагыг албан ёсоор төлөөлж буй аливаа этгээд;
- (b) Улс төрийн намын аливаа ажилтан, албан хаагч, албан тушаалтан;
- (c) Төрийн байгууллагад нэр дэвшигч аливаа этгээд; эсхүл
- (d) Олон улсын нэр бүхий байгууллага (жишээлбэл НҮБ, ОУ Валютын Сан, Дэлхийн Банк)-ын аливаа ажилтан, албан тушаалтан зэргийг хэлнэ.

Монгол улсын нутаг дэвсгэрээс гаднах үйлчилгээ гэж Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна бодитоор гүйцэтгэж, үзүүлж буй бөгөөд суутган тооцох татвараас чөлөөлөгдөх Үйлчилгээг хэлнэ.

ХАБЭА-н тухай хууль гэж 1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль, 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухайн хууль, Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/114 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив”, Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн А/33 тоот тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт явах журам”, мөн тухай бүр баталж, нэмэлт өөрчлөлт оруулсан холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, нормативыг хэлнэ.

Монгол улсын нутаг дэвсгэр дэх үйлчилгээ гэж Монгол улсын нутаг дээр дотор бодитоор гүйцэтгэж, үзүүлж буй Үйлчилгээг хэлэх бөгөөд уг Үйлчилгээнд 20%-ийн суутган тооцох татвар ногдуулж болно (үүнд холбогдох татварын гэрээ хэлэлцээрийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт бодогдож болно).

Тал гэж энэхүү гэрээний аль нэг талыг хэлнэ.

Төлбөрийн нөхцөл гэдгийг Худалдан авах захиалгад тодорхойлов.

Хувийн мэдээлэл гэж (a) тухайлсан хувь хүний оршин суугаа, (b) тухайн хувь хүнтэй холбоотой мэдээллийг боловсруулсан улсад мөрдөх хувь хүний нууцын тухай хууль болон мэдээлэл хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан тухайлсан хувь хүнтэй холбоотой бүх мэдээллийг хэлнэ.

Ажиллах хүч гэж:

- (a) Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотойгоор түүний аливаа ажилтан, туслан гүйцэтгэгч (түүний ажиллах хүчин), Үйлчилгээний үзүүлэх, гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцогч агент ба төлөөлөгч нар;
- (b) Компани эсхүл Рио Тинто Группийн аль нэг гишүүнтэй холбоотойгоор түүний өмнөх болон одоогийн ажилтан, албан хаагчид, агентууд ба төлөөлөгч нар;
- (c) Туслан гүйцэтгэгчтэй холбоотойгоор түүний аливаа ажилтан, Үйлчилгээ үзүүлэх, гүйцэтгэхэд шууд болон шууд бусаар оролцогч агент ба төлөөлөгч нарыг хэлнэ.

Ашиглах гэж цуглуулах, эзэмших, ашиглах, шилжүүлэх, устгах болон аливаа бусад үйл ажиллагааг хэлнэ.

Худалдан авах захиалга гэж энэхүү гэрээний нөхцөлд заасан Үйлчилгээ үзүүлэх, дагалдах барааны нийлүүлэлттэй холбогдуулан Компаниас Үйлчилгээ үзүүлэгчид гаргах бараа худалдан авах захиалгыг хэлнэ.

Рио Тинто Групп гэж Рио Тинто плс ба Рио Тинто Лимитэдээс бүрдэж буй давхар бүртгэлтэй компанийн бүтцийг хэлэх бөгөөд үүнд:

- (a) Рио Тинто плс болон Рио Тинто Лимитэдийн аливаа Салбар компани,
- (b) Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэд эсвэл Рио Тинто плс болон Рио Тинто Лимитэдийн аливаа Салбар Компани хувьцааны 50-аас доошгүй хувийг нь эзэмшдэг аливаа бүртгэгдээгүй бизнесийн хамтарсан нэгдэл,

(c) Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэд эсвэл Рио Тинто Плс болон Рио Тинто Лимитэдийн (үүнд “Оюу толгой” ХХК) аливаа Салбар Компани менежментийг нь хэрэгжүүлдэг аливаа бүртгэгдээгүй бизнесийн хамтарсан нэгдэл, болон

(d) Талуудын бичгээр хүлээн зөвшөөрсөн бусад этгээдийг оролцуулна.

Рио Тинто Лимитэд гэж Викториа, 3000, Мелбурн хот, Коллинс Гудамж 120, давхар 33-т хаягийн бүртгэлтэй, Рио Тинто ХХК (ABN 96 004 458 404)-ийг хэлнэ.

Рио Тинто Плс гэж Нэгдсэн Вант Улс, Лондон хотW2, 6LG, Истбурн террас 2 дахь Рио Тинто ХК (Компанийн дугаар: 719885)-ийг хэлнэ.

Үйлчилгээ үзүүлэгч гэж Үйлчилгээг үзүүлэх үүрэг бүхий Талыг хэлнэ (Худалдан авах захиалгад тодорхойлсны дагуу)

Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргийг зөрчсөн тухай мэдэгдэл гэдгийг 28.1-д тодорхойлов.

Үйлчилгээ үзүүлэгчийн даатгал гэдгийг 25.1-т тодорхойлов.

Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгч гэж Худалдан авах захиалгад тодорхойлсон Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгчийг хэлнэ.

Үйлчилгээ гэж Гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэхээр Худалдан авах захиалгад тодорхойлсон, шаардлагатай холбогдох барааны нийлүүлэлт бүхий Үйлчилгээг хэлнэ.

Уурхайн цогцолбор гэж Худалдан авах захиалгад заасан Компанийн газар, барилга байгууламжийг хэлнэ.

Үзүүлэлт гэж үйлчилгээнд тавигдах техникийн тодорхойлолт болон гэрээний дагуу Компанийн төлөөлөгчийн зааварчилгаагаар тухайн тодорхойлолтод оруулсан аливаа өөрчлөлтийг хэлнэ.

Туслан гүйцэтгэгч гэж 36-р заалтын дагуу Үйлчилгээний аль нэг эсхүл бүх хэсгийг Үйлчилгээ үзүүлэгчийн өмнөөс гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

Нийлүүлэлтийн гинжин хэлхээ гэж компанид Үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэж эхлэхээс Компани Үйлчилгээг ашиглаж дуусах хүртэлх үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой бүхий л үе шат, явцыг хэлнэ.

Татвар буюу татварууд гэдэгт эсрэг утга санаа илэрхийлээгүй бол, аль нэг Засгийн Газрын эрх бүхий байгууллагаас тогтоосон, ногдуулсан ба нэхэмжилсэн буюу төлбөл зохих бүх татварууд, мөн үүгээр үл хязгаарлагдах аливаа шууд бус гүйлгээний татвар, онцгой албан татвар, тэмдэгтийн хураамж, баримт бичиг бүрдүүлэлтийн хураамж, гаалийн татвар, импорт/экспортын татвар, цалингийн шимтгэл, хувь хүний татвар, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн татвар, ашгийн тэнцэтгэлийн татвар, бизнесийн татвар, мэргэжлийн татвар, эргэлтийн хөрөнгийн татвар, орлогын албан татвар, корпорацийн татвар, хөрөнгийн татвар, ашгийн татвар, нийт олсон орлогод ногдуулах татвар болон бусад татвар хураамж болон бусад төлбөр, хүн амын орлогын албан татвар, гаалийн хураамж, шимтгэл, суутгал зэрэг аль ч үед ногдуулах боломжтой аливаа хэлбэрийн татвар хураамжууд тэдгээрт тооцсон алданги, торгууль, хүү болон түүнтэй төстэй бүх нэмэгдэл төлбөрүүдийг хамтатган ойлгоно. Эргэлзээнээс зайлсхийхийн тулд тодорхойлоход “Татварууд” гэдэгт Монгол ажиллах хүчний төлбөр орно.

Тендер гэж тухайн үйлчилгээг үзүүлэх тухай “тендер” болон “санал” гэж, эсхүл өөрөөр нэрлэж тодорхойлсон үйлчилгээ гүйцэтгэхэд Үйлчилгээ үзүүлэгчийн бичгээр өгч буй санал, эсхүл хариу саналыг хэлнэ.

Хугацаа гэж 7-р заалтанд заасан өдөр, хугацааг хэлнэ.

Гэрээ цуцлах мэдэгдэл гэдгийг 26.1-д тодорхойлов.

1.2 Тайлбар

Гарчиг нь зөвхөн ойлгомжтой байлгах үүднээс өгсөн бөгөөд гэрээний тайлбарт нөлөөлөхгүй. Агуулгад тусгайлан өөрөөр заагаагүй тохиолдолд дор дурдсан дүрмийг мөрдөнө.

(a) Ганц тоогоор илэрхийлсэн үг олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

(b) Хүйс гэдэг үг бүх хүйсийг илэрхийлнэ.

(c) Хэрэв үг ба хэллэг нь тодорхойлогдсон бол тухайн үг/хэллэгийн бусад өгүүлбэрзүйн хэлбэрүүд нь тухайн утгаар хэрэглэгдэнэ.

(d) Ерөнхий үг хэллэгийн утга нь түүнийг жишээнд оруулж тайлбарласан тодорхой жишээгээр үл хязгаарлагдана.

(e) Этгээд гэж корпораци, итгэлцэл, хамтын ажиллагаа, түншлэл, хувь нийлүүлсэн бус байгууллага эсхүл бусад байгууллагын тухай бол бүгдээрээ байж болно.

(f) Хувь хүн эсхүл гэрээний аль нэг тал гэдэгт уг хүний эсхүл тухайн талын гүйцэтгэгч, албан тушаалтан, өв залгамжлагчид, орлогч (үүргийг нь албан ёсоор хүлээж авсан этгээдийг оролцуулан), эрх

шилжүүлж авсан хүн (хувь хүн бол), эрх шилжүүлж авахыг нь зөвшөөрсөн тал (гэрээний аль нэг тал бол) зэргийг оруулна.

- (g) Заалтыг энэхүү “Ерөнхий нөхцөл”-ийн заалт гэж ойлгоно.
- (h) Хууль тогтоомж болон хууль тогтоомжийн нөхцөл нь заалтуудад тэдгээрийн өөрчлөлт болон дахин шинэчлэн найруулсан батлах хувилбар, үүнд нэмсэн хуулинд орсон хууль зүйн нөхцөл болоод болон түүний хүрээнд батлан гаргасан тогтоомж, хууль ёсны баримт бичгийг хамаарна.
- (i) Оюуны өмчийн эрхтэй холбоотой агуулгыг хэрэглэх бол түүнийг хэрэглэх, ашиг шимийг нь хүртэх, хуулбарлах, тохируулан өөрчлөх, түүнээс үүсмэл зүйлсийг бий болгох, хөгжүүлэх, өөрчлөх, задруулах болон дамжуулах зэргийг багтаан ойлгоно.
- (j) Зохион байгуулах гэдэгт эс үйлдэхүй, бичгийн эсхүл бичгийн бус мэдээлэл, үйл ажиллагаа зэргийг илэрхийлэх бөгөөд үүгээр үл хязгаарлагдана..
- (k) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч аливаа ажиллагаа явуулах эсхүл эд зүйлийг нийлүүлэхдээ түүнд харгалзах зардалд нь багтаан гүйцэтгэнэ гэж заасан бол энэ нь Үйлчилгээ үзүүлэгч тухайн ажил эсхүл эд зүйлийн төлөө ямарваа нэгэн нэмэлт урамшуулал авах эрхгүй бөгөөд уг зардлыг Гэрээний үндэс багтсан гэж ойлгоно.
- (l) Компани нь Гэрээнд тусгасан бүхий л хөнгөлөлт, чөлөөлөлт, хязгаарлалт, хамгаалалт, урамшуулал, нөхөн төлбөрийн баталгаа болон бусад дэмжлэгийг өөрийн ажилтан, албан хаагч нар болон Рио Тинто Группийн гишүүн, түүний ажилтнуудад үзүүлэх бөгөөд Рио Тинто Группийн гишүүн, түүний ажилтнуудын хувьд батлан даагч болж сахин хамгаална.
- (m) Компани болон Рио Тинто Группийн гишүүн эсхүл тэдний холбогдох ажилтан нь Гэрээнд заасны дагуу нөхөн төлбөрийн эрхийг хэрэгжүүлэхийн өмнө ямар нэгэн зардал гаргах эсхүл төлбөр хийх шаардлагагүй.
- (n) Гэрээний дагуу төлөх ёстой аливаа мөнгөн дүнг төлөх өдөр нь Ажлын өдрөөс бусад өдөр таарвал тухайн төлбөрийг дараагийн Ажлын өдөр хийнэ.

2. Гэрээний нотлох баримт, баримт бичгийг давууд үзэх дараалал

2.1 Гэрээ

Дор дурдсан баримт бичиг нь тус гэрээг бүрдүүлнэ. Үүнд:

- (a) Худалдан авах захиалга
- (b) Эдгээр Ерөнхий нөхцөл
- (c) Худалдан авах захиалга болон эдгээр Ерөнхий нөхцөлд хавсаргасан буюу эдгээрт дурдсан аливаа бусад баримт бичиг.

2.2 Гэрээний баримт бичгийг давууд үзэх дараалал

Хэрэв Гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдөх буюу үл нийцвэл, өөрөөр заагаагүй бол тэдгээр баримт бичгийг 2.1-д дурдсан дарааллын дагуу давууд үзэж шийдвэрлэнэ.

2.3 Гэрээний бүрэн бүтэн байдал

- (a) Энэ Гэрээ нь агуулгын хувьд Компани ба Үйлчилгээ үзүүлэгчийн хоорондын эцсийн тохиролцоо болох бөгөөд эдгээр харилцаа нь Гэрээний нэг хэсгийг бүрдүүлж буйг илэрхийлсэнээс бусад тохиолдолд талуудын хооронд урьд өмнө үйлдсэн бүх харилцаа, хэлцлийг орлон шинээр тогтооно.
- (b) Үйлчилгээ үзүүлэгчийн хэвлэмэл нөхцлүүд, Үйлчилгээ үзүүлэгчийн аливаа үнийн санал, нэхэмжлэх, захиалга хүлээн авсан тухай мэдэгдэл, баталгаажуулалт, хүлээн авалт, ачилт буулгалтын төлбөрийн баримт болон бусад баримт бичиг зэрэг энэхүү ерөнхий нөхцөл болон Худалдан авах захиалганд тусгасан нөхцөл дээр аль нэг талаас нэмсэн, тэдгээрээс өөр эсхүл тэдгээртэй үл нийцэх аливаа нөхцлийг аль аль талын эрх бүхий төлөөлөгч нар тусгайлан бичгээр харилцан тохиролцож, гарын үсэг зураагүй бол талууд заавал биелүүлэхгүй.

2.4 Бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах

Үйлчилгээ үзүүлэгч ба Компани бичгээр үйлдэж гарын үсэг зурснаас бусад тохиолдолд Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь хүчин төгөлдөр бус байна.

3. Мэдээллийн үнэн зөв байдал

3.1 Компаниас мэдэгдэл өгөхгүй

Компани нь, Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтан сайттай танилцаж, тендерийн өмнөх уулзалт эсхүл өөр бусад байдлаар Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтны Компаниас олж авсан эсхүл тэдэнд өгсөн аливаа мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулахыг (үүнийг хийх үүргийг хүлээхгүй) хичээн ажилладаг бөгөөд цаашид ч хичээх болно. Гэвч Компани нь тухайн мэдээллийн үнэн зөв, хүрэлцээтэй байдлын талаар баталгаа эсхүл батлан даалт гаргахгүй бөгөөд тухайн мэдээллийн талаар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Ийнхүү өгсөн мэдээлэл нь зөвхөн Үйлчилгээ үзүүлэгчид дөхөм байх үүднээс өгсөн гэдгийг Талууд хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ нь Талуудын бичгээр тусгайлан зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд Гэрээний нэг хэсэг болохгүй. Мөн Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн аливаа Тендер, түүний улмаас хэрэгжиж буй Гэрээний гүйцэтгэл, хэрэгжилтийг Үйлчилгээ үзүүлэгчийн өөрийнх нь хяналт шалгалт ба олж тогтоосон зүйлс дээр тулгуурласан гэж үзнэ.

3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь үнэн зөв байдалд ханамжтай байх

Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний гүйцэтгэлээс өмнөх хугацаанд түүнд өгсөн аливаа мэдээллийн үнэн зөв байдалд сэтгэл хангалуун байсан бөгөөд тухайн мэдээллийг аливаа хэлбэрээр ашигласны буюу тухайн мэдээллээс урган гарсан аливаа дүгнэлтийн хариуцлагыг оролцуулан ямар нэгэн хязгаарлалтгүй, бүрэн хариуцлагыг хүлээнэ гэдгийг зөвшөөрч байна.

3.3 Үүргээс чөлөөлөхгүй байх

Үйлчилгээ Үзүүлэгч нь бүх нөхцөл эсхүл аль нэгийг нь биелүүлж чадаагүй тохиолдолд энэхүү Гэрээнд заасан аливаа үүргээс 4-д заасны дагуу чөлөөлөгдсөн гэж үзэхгүй.

3.4 Компани хариуцлага хүлээхгүй байх

Компанийн Үйлчилгээ үзүүлэгчид өгсөн аливаа мэдээллийг ашигласны улмаас Үйлчилгээ үзүүлэгч ямар нэг хохирол амссан эсхүл хүндрэл учирсан тохиолдолд Компани хариуцлага хүлээхгүй.

4. Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний гүйцэтгэл

4.1 Гүйцэтгэл

Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу Гэрээний үнэд багтаан үйлчилгээг гүйцэтгэх ёстой.

4.2 Илгээх бараа

Гэрээнд илгээсэн ачааны тухай заалт орсон бол Үйлчилгээ үзүүлэгч нь Ачааг Гэрээний дагуу хүргэх үүрэгтэй. Илгээсэн ачааг агуулахаас гаргаж, Компани түүнийг хэрэглэх хүртэл тухайн Ачааг Компанийн зүгээс худалдан авсан эсхүл захиалсан гэж үзэхгүй.

5. Үйлчилгээ үзүүлэгчийн баталгаа

5.1 Үйлчилгээ үзүүлэгчийн баталгаа

Үйлчилгээ Үзүүлэгч нь 32.1 болон 6.2-д заасан баталгаанаас гадна дор дурдсан баталгааг өгнө. Үүнд:

- (a) бүх Үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, журам дүрмийн дагуу үр ашигтай байдлаар үзүүлнэ;
- (b) бүх үйлчилгээ нь Компанийн өгсөн тодорхойлолт, шаардлагад (тухайн тодорхойлолтой Үйлчилгээ үзүүлэгч танилцсан байгаа тохиолдолд) нийцсэн хамгийн өндөр стандартыг хангахуйц байх, хэрэв тийм шаардлага байхгүй бол Олон улсын стандартчлалын байгууллагаас гаргасан тохирох стандарт (ISO), хэрэв тийм стандарт байхгүй бол Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн холбогдох стандартын дагуу байна;
- (c) Үйлчилгээний гүйцэтгэлтэй холбоотойгоор:
 - (i) Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтнууд нь ижил төстэй, өрсөлдөхүйц чадвар бүхий этгээдийн ажил гүйцэтгэхдээ байнга баримталдаг хичээл зүтгэл, туршлага, чадвар ба анхаарал болгоомжийн стандарт буюу зарчмыг хангаж ажиллана гэдгийг;
 - (ii) Үйлчилгээ үзүүлэгчийн сайтад хэрэглэж буй аливаа тоног төхөөрөмж нь Компанийн шаардлагын түвшинд хүртэл аюулгүй ажиллагааны нөхцөлд байж, тухайн тоног төхөөрөмжид холбогдох бүх хууль тогтоомжид нийцсэн, түүнийг ажиллуулах мэргэжилтнүүд нь чадварлаг ажиллах хүчин гэдгийг; мөн түүнчлэн;
- (d) Үйлчилгээний нэг хэсэг болох холбогдох бараа бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотойгоор:
 - (i) Холбогдох бараа бүтээгдэхүүн нь худалдааны чанарын шаардлага хангасан;
 - (ii) Холбогдох бараа бүтээгдэхүүн нь загвар дизайн, материал ба хийц чанарын хувьд дутагдалгүй бөгөөд Холбогдох бараа бүтээгдэхүүний зорилгод тохирсон;

- (iii) Холбогдох бараа бүтээгдэхүүн нь сайн, зах зээлийн нэр хүнд бүхий байх бөгөөд Компани нь Холбогдох бараа бүтээгдэхүүний өмчлөх эрхийг ямар нэг үнэ хөлс эсхүл хүндрэл чирэгдэлгүйгээр хүлээн авахыг;
- (iv) Ердийн худалдааны бүх баталгаа ба Компанийн тусгайлан хүссэн аливаа баталгааг өөрийнх нь өртгөөр нь олж авах ба Үйлчилгээг гүйцэтгэж дуусах үед хугацаа дуусаагүй аливаа баталгаанаас ашиг хүртэх эрхийг Үйлчилгээ үзүүлэгчийн туслан гүйцэтгэгчээс гарган өгсөн баталгааг оролцуулан Компанид шилжүүлэн өгөхийг;
- (e) Тендерийн аливаа хэсгийг бүрдүүлж байгаа бүх төрлийн мэдээлэл, материал нь (хэрэв байгаа бол) бүгд үнэн зөв, алдаа мадаггүй, худал мэдүүлсэн зүйлгүй бөгөөд Компани нь Үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах эсэхийг шийдэх материал болох тул Үйлчилгээ үзүүлэгчийн туршлага болон мэргэшсэн байдлын талаархи мэдээлэл эсхүл тухайн Үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор Компанийн бэлдвэл зохих нөхцөл шаардлага, түүний үнэтэй холбоотой мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгч нь Компаниас нуун далдлаагүй гэдэгт тус тус баталгаа өгнө.

5.2 Худалдааны баталгааны хуулбар хувь

Үйлчилгээ үзүүлэгч нь 5.1(d)(iv)-д заасан худалдааны баталгааны хуулбарыг Худалдааны нэхэмжлэхийн хамт Компанид өгөх ёстой.

6. Доголдол, Зөрчил дутагдлыг арилгах

6.1 Доголдолтой үйлчилгээг засах

Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээ хэрэгжих хугацаанд Үйлчилгээний аливаа доголдлын (6.2, 6.3, 6.4 заалтууд хэрэглэгдэхтэй холбоотой Холбогдох бараа бүтээгдэхүүний доголдлоос бусад,) талаар Компанийн төлөөлөгчийн мэдэгдлийг хүлээн авмагц уг доголдлыг (тухайн доголдлыг засахад шаардлагатай арга зам бүхий нэмэлт үйлчилгээг оролцуулан) мэдэгдэлд заасан хугацаанаас өмнө, Компаниас ямар нэгэн зардал гаргуулахгүйгээр зохих ёсоор засах ёстой.

6.2 Баталгаа

Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох бараа бүтээгдэхүүн бүрийн хувьд баталгаат хугацааны туршид гарсан аливаа доголдлыг арилгах тухайгаа батална.

6.3 Баталгаат хугацаа эхлэх

Холбогдох бараа бүтээгдэхүүн бүрийн хувьд (Ачааг оруулахгүйгээр) Баталгаат Хугацаа нь Компани тухайн Холбогдох бараа бүтээгдэхүүнийг бичгээр хүлээн хүлээн авсан өдрөөс эхэлнэ. Ачааны хувьд Баталгаат Хугацаа нь Холбогдох бараа бүтээгдэхүүнийг Компанийн агуулахаас гаргасан өдрөөс эхэлнэ.

6.4 Зөрчил, дутагдлыг арилгах

Бараа бүтээгдэхүүний алдаатай загвар/зураг төсөл, материал, хийц, худалдааны чанарыг үл хангасан эсхүл зориулалтын бус байдал зэргийн улмаас баталгаат хугацаанд аливаа бараанд гологдол, дутагдал гарсан талаар Компанийн төлөөлөгчийн мэдэгдлийг хүлээн авснаар Үйлчилгээ үзүүлэгч тухайн зүйл, эд ангийг мэдэгдэлд заасан хугацаанаас өмнө, Компаниас ямар нэгэн зардал гаргуулахгүйгээр зохих ёсоор загвар/зураг төслийг дахин боловсруулах, засах, солих ёстой.

6.5 Үйлчилгээ үзүүлэгч зөрчил, дутагдлыг арилгахгүй байх

Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь (тухайн шаардлагатай тохиолдолд):

- (a) 6.1-д зааснаар Компаний олж илрүүлсэн Үйлчилгээний аливаа доголдлыг засч арилгаагүй, эсхүл
- (б) 6.4-д зааснаар Компаний олж илрүүлсэн Холбогдох бараа бүтээгдэхүүний доголдлыг засч сайжруулаагүй тохиолдолд,

Компани нь Үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэл, зардлаар Үйлчилгээний аливаа зөрчил, дутагдал эсхүл Холбогдох бараа бүтээгдэхүүний доголдлыг засч сайжруулж болох бөгөөд Компанид учирсан аливаа зардал нь Үйлчилгээ үзүүлэгчийн Компанид төлөх ёстой өр болж үлдэнэ.

7. Хугацаа

Үйлчилгээ үзүүлэгч Худалдан авах захиалгыг хүлээн авсан тухай мэдэгдэл хүргүүлсэн эсхүл Үйлчилгээ үзүүлэгч Үйлчилгээг гүйцэтгэж эхлэсэн өдрийн аль түрүүлж тохиосон өдрөөс эхлэн Гэрээ хэрэгжиж эхлэх бөгөөд Гэрээнд заасны дагуу хугацаанаас өмнө цуцлаагүй бол Үйлчилгээ үзүүлэгч энэхүү Гэрээний дагуу хүлээсэн бүх үүргээ гүйцэтгэж дуусах хүртэл Гэрээ хүчин төгөлдөр хэрэгжинэ (**Гэрээний хугацаа**).

8. Төлөөлөл

8.1 Гэрээний гүйцэтгэл

Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний дагуу, гэрээнд заасан Компанийн төлөөлөгчийн удирдамж дор Үйлчилгээг үзүүлэх ёстой.

8.2 Компанийн төлөөлөгч

- (a) Компанийн төлөөлөгч нь Компанийг төлөөлж түүний нэрийн өмнөөс Гэрээнд заасны дагуу удирдамж, чиглэл өгөх үүрэгтэй.
- (b) Компанийн төлөөлөгчөөс бусад хэн нэгэн этгээдийн Үйлчилгээ үзүүлэгчид өгсөн удирдамж, чиглэлийг Компанийн төлөөлөгч баталгаажуулаагүй тохиолдолд Компанид холбогдолгүй байна.

8.3 Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгч

- (a) Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгч нь 8.2-д заасантай хамаарах аливаа асуудлаар Компанийн төлөөлөгчтэй харилцан уялдаатай ажиллах үүрэгтэй бөгөөд Гэрээнээс урган гарах бүхий л асуудлын хүрээнд Үйлчилгээ үзүүлэгчийг хууль ёсоор төлөөлөх бүрэн хэмжээний эрх мэдэлтэй байна.
- (b) Компанийн төлөөлөгчөөс Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгчид өгсөн аливаа удирдамж, чиглэл нь Компанийн нэрийн өмнөөс Үйлчилгээ Үзүүлэгчид өгсөн гэж тооцогдох бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн чиглэлийг мөрдөж ажиллах ёстой. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгчийн хийсэн аливаа харилцаа холбоо, гарын үсэг зурсан баримт бичгүүдийг Үйлчилгээ үзүүлэгч үйлдсэн гэж тооцогдох бөгөөд үүний хариуцлагыг Үйлчилгээ үзүүлэгч хүлээнэ. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөгчийн мэдэж буй асуудлын талаар Үйлчилгээ үзүүлэгч мөн адил мэдэж байгаа гэж үзнэ.
- (c) Аль ч Тал нь гэрээний хугацааны туршид өөрийн төлөөлөгчийг буцаан татах буюу татгалзах эсхүл түүний оронд өөр хүнийг томилж болох бөгөөд уг Тал нь энэ тухай мэдэгдлийг нөгөө талдаа өгөх ёстой.

9. Хүргэлт, өмчлөх эрх, эрсдэл

9.1 Хүргэлт

Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох бараа бүтээгдэхүүнийг Хүргэлтийн цэгт (хэрэв байгаа бол) хүргэж өгөх ёстой. Холбогдох бараа бүтээгдэхүүнийг Гэрээнд заасан хугацаанд нь болон түүнээс өмнө Хүргэлтийн цэгт бүрэн бүтэн хүргэх үүргийн хувьд цаг хугацаа нэн чухал.

9.2 Өмчлөх эрх

Дор дурдсан тохиолдлын аль түрүүлж тохиосноор Ачааг өмчлөх бүрэн эрх Компанид шилжин очно. Үүнд:

- (a) Компани нь тухайн Холбогдох бараа бүтээгдэхүүний үнийг Үйлчилгээ үзүүлэгчид бүрэн төлсөн; эсхүл
- (b) Холбогдох бараа бүтээгдэхүүн нь Хүргэлтийн цэгт (хэрэв байгаа бол) хүргэгдсэн бөгөөд 18-д заасны шалгалт хийж, Компанийн төлөөлөгч хүлээн авсан зэрэг болно.

9.3 Эрсдэл

Холбогдох бараа бүтээгдэхүүн бүрийн Компанийн төлөөлөгчид хүргэж, хүлээн авахаас өмнөх эрсдэлийг Үйлчилгээ үзүүлэгч хүлээнэ.

10. Гэрээний үнэ

10.1 Гэрээний үнэ

Гэрээний үнэ гэдэг нь Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор Компанийн Үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой (11-д заасны дагуу төлөх ёстой аливаа Шууд бус гүйлгээний татварыг оролцуулахгүйгээр) нийт үнийн дүнг хэлнэ.

10.2 Гэрээний үнэд багтах зардал

- (a) Унааны ба томилолтын зардал, төлөх ёстой аливаа татвар хураамж зэргийг гэрээний үнэд багтаасан гэж үзэх бөгөөд мөн үүгээр үл хязгаарлагдан Үйлчилгээ үзүүлэгчээс Үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон гарах бүх зардал;
- (b) Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний үнэд багтсан аливаа Гаалийн татварын талаарх мэдээллийг Компанид тусад нь мэдэгдэх ёстой.

11. Татвар,

11.1 Татвар, Шууд бус гүйлгээний татвар, Суутгах татвар – Гадаадын үйлчилгээ үзүүлэгч

- (a) Үйлчилгээ үзүүлэгч нь Гадаадын үйлчилгээ үзүүлэгч бол энэхүү 11.1-р заалт үйлчилнэ.

- (b) Үйлчилгээ үзүүлэгч нь Татвартай холбоотой бүх Холбогдох хууль тогтоомж болон аливаа Төрийн байгууллагын захиргааны шаардлагыг өөрийн зардлаар дагаж мөрдөх үүрэгтэй.
- (c) Татварын төлөлт
- (i) Доорх 11.1 (c) (ii)-д зааснаас бусад тохиолдолд, Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү Гэрээний дагуу Үйлчилгээг хийж гүйцэтгэхтэй (эсхүл аливаа барааг хүргэхтэй) холбогдуулан дэлхийн аль ч хэсэгт аливаа Төрийн байгууллагаас ногдуулсан аливаа бөгөөд бүх Татварыг төлөх (энэхүү 11.1 (c)(i) заалтанд суутгах, шилжүүлэх гэсэн хамаарах утгаар орох) үүрэг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох хуулийн дагуу олгох НӨАТ-ын бүх хөнгөлөлт, буцаан төлөлтийг авах өргөдөл гаргаж, түүнийг эдлэх бүхий л хүчин чармайлтаа гаргана. Үйлчилгээ үзүүлэгч нь мөн бараа бүтээгдэхүүнд (хэрэв байгаа бол) оруулахаар төлөвлөж буй аливаа материал болон эд ангид төлөх гаалийн болон импортын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт авах тал дээр Компанитай зөвлөлдөн, хамтран ажиллах бөгөөд түүнийг эдлэх бүхий л хүчин чармайлтыг гаргана. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх бүх Татварыг Гэрээний үндэс багтаах бөгөөд Гэрээний үнэ дээр нэмэхгүй.
- (ii) Доорх 11.1 (c)(iii)-д заасантай холбогдуулан Компани нь энэхүү Гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн Үйлчилгээнд холбогдуулан Монгол улсын засгийн газраас эсхүл түүний эрх бүхий байгууллагаас ногдуулсан дараах Татварыг Монгол улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн Үйлчилгээнд (эсхүл хүргэсэн Бараа бүтээгдэхүүн) ногдуулна. Компани нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай Монгол улсын хууль ("Монгол улсын НӨАТ")-ийн 3-р бүлгийн дагуу уг Үйлчилгээнд (эсхүл бараа бүтээгдэхүүнд) ногдуулсан аливаа Монгол улсын нэмэгдсэн өртгийн албан татварыг төлөх үүрэг хүлээнэ.
- (iii) Шууд төлөхийг хуулиар зөвшөөрсөн тохиолдолд Компани 11.1 (c)-д заасан аливаа Татварыг Монголын холбогдох татварын албанд шууд төлнө. Шууд төлөхийг хуулиар зөвшөөрөөгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр Татварыг төлж, Компани тухайн төлсөн татварын дүнг Үйлчилгээ үзүүлэгчид нөхөн төлнө.
- (d) Үйлчилгээ үзүүлэгч нь Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж болон хувь хүн биш тул Компани гагцхүү Монгол улсын хуулиар шаардсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрөөс суутгах татвар суутгана. Энэ тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн хүргүүлсэн анхны Худалдааны нэхэмжлэхээс эхлэн Компани нь түүний хуулиар суутгах үүрэг бүхий суутгах татварыг Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрөөс суутгаж, зохих Төрийн байгууллагад шилжүүлэн, зохих төлбөрийн баримт болон ижил төстэй баримт бичгийг төлбөр шилжүүлсэний баталгаа болгон Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ. Компаниас төлөх эдгээр суутгах татварыг Гэрээний үндэс багтаах бөгөөд Гэрээний үнэ дээр нэмж төлөхгүй.
- (e) Үйлчилгээ үзүүлэгч Монгол улсын нутаг дэвсгэр дээр Үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчийн харьяа улс нь Монгол улстай давхар татварын гэрээ байгуулсан бол татвар төлөгчийн гэрчилгээ шаардлагатай болно. Үйлчилгээ үзүүлэгч нь Гадаадын үйлчилгээ үзүүлэгч бол Компанид өгөх анхны нэхэмжлэхийг холбогдох бүх татварын байгууллагаас гаргасан хүчин төгөлдөр татвар төлөгчийн гэрчилгээний хамт жил бүр ирүүлнэ. Үйлчилгээ үзүүлэгч нь хүчин төгөлдөр татвар төлөгчийн гэрчилгээг ирүүлээгүй эсхүл тухайн татвар төлөгчийн гэрчилгээ нь Монгол улс болон Үйлчилгээ үзүүлэгчийн харьяа улсын хооронд байгуулсан давхар татварын гэрээний дагуу Монгол улсын аливаа суутгах татвараас чөлөөлөгдөх, хөнгөлүүлэх хангалттай үндэслэл болохгүй гэж Компаниас үзсэн тохиолдолд Компани нь Ерөнхий нөхцлийн дагуу суутгах татварыг Монгол улсын хуулиар тогтоосон бүрэн хэмжээгээр суутгана.
- (f) Гадаадын үйлчилгээ үзүүлэгч нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр аливаа Үйлчилгээ үзүүлсэний үр дүнд Монгол улсад байнгын ажлын байр байгуулах нөхцөл бүрдсэн тохиолдолд Компанид нэн даруй мэдэгдэж, Монгол улсын орлогын албан татвар төлөх зорилгоор бүртгүүлж, татварын буцаан төлөлтийн өргөдлөө гарган Монгол улсын нутаг дэвсгэр дээр үзүүлсэн эдгээр Үйлчилгээнээс олсон орлогод ногдуулсан татварыг төлнө. Тухайн байнгын ажлын байр байх хугацаанд Компани суутгах татвар суутгахгүй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа суутгах татвар болон түүнтэй холбогдох торгууль, алданги, хүү зэргийг төлөөгүйн улмаас гарах аливаа татварын өр төлбөрөөс Компанийг хохиролгүй болгоно.
- (g) Үйлчилгээ үзүүлэгч нь дараах зүйлсийн Худалдааны нэхэмжлэхийг тусад нь гаргана. Үүнд:
- (i) Бараа бүтээгдэхүүн,
- (ii) Монгол улсын нутаг дэвсгэр дээрх үйлчилгээ
- (iii) Монгол улсын нутаг дэвсгэрээс гаднах үйлчилгээ
- (iv) Нөхөн төлөгдөх зардал гэж тайлагнасан зардлууд.
- (h) Үйлчилгээ үзүүлэгч нь Компанид бичгээр хүсэлт гаргасны үндсэн дээр дараах зүйлсийг Компанид ирүүлнэ. Үүнд:

- (i) Засгийн газрын эрх бүхий байгууллагаас хүссэн компанийн бүртгэл болон НӨАТ-ын бүртгэлийн гэрчилгээ зэрэг татварын мэдээллийг Компанийн зүгээс олгоход шаардлагатай аливаа болон бусад бүх мэдээлэл, маягтууд.
 - (ii) Компанийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулгаар гаргасан Худалдааны нэхэмжлэх.
- (i) Энэхүү Гэрээний дагуу Компанийн Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрт суутгах татварын суутгал багтаагүй боловч холбогдох хуулиар суутгал хийх шаардлагатай бол, эсхүл энэхүү Гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрт суутгах татварын суутгал багтаагүй боловч холбогдох хуулиар илүү өндөр хэмжээний суутгал хийх шаардлагатай бол Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн суутгах шаардлагатай байсан эсхүл илүү өндөр хэмжээгээр хийх байсан суутгалын хэмжээг тусгасан албан ёсны төлбөрийн баримт (эсхүл түүний баталгаажсан хуулбар) болон бусад баримт бичгийг хүлээн авсанаас хойш арван дөрвөн (14) хоногийн дотор Компанид тухайн суутгах шаардлагатай байсан эсхүл илүү өндөр хэмжээгээр хийх байсан суутгалын хэмжээг нөхөн төлөх эсхүл төлж барагдуулна.
- (j) Татвар, татварын хуулиар хүлээсэн үүргээ Нийлүүлэгч эсхүл аливаа туслан гүйцэтгэгч биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа болон бүх хүлээх хариуцлага, нэхэмжлэл шаардлага, хохирол, зардлаас (өмгөөлөгчийн төлбөр, торгууль, шийтгэл, алданги зэргийг багтаана) Үйлчилгээ үзүүлэгч Компанийг чөлөөлөх, хохиролгүй болгох, компанийг эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.

11.2 Татвар, шууд бус гүйлгээний татвар, суутгах татвар – Дотоодын монгол үйлчилгээ үзүүлэгч

- (a) Үйлчилгээ үзүүлэгч нь Дотоодын монгол үйлчилгээ үзүүлэгч бол энэхүү 11.2-р заалт үйлчилнэ.
- (b) Үйлчилгээ үзүүлэгч нь Татвартай холбогдох бүх хууль тогтоомж, зохицуулалт болон аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагын захиргааны шаардлагыг мөрдөх ба өөрийн зардлаар хариуцах үүргийг хүлээнэ.
- (c) Татвар төлөлт
- (i) Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү Гэрээнд заасан үйлчилгээний гүйцэтгэлтэй (эсхүл аливаа бараа бүтээгдэхүүний хүргэлт) холбоотойгоор дэлхийн аль ч орны Засгийн газрын аливаа захиргааны байгууллагын шаардлагын дагуу ногдуулсан бүх төрлийн татварыг төлөх (энэхүү 11.2 (c) дүгээр заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор, суутгал болон хөнгөлөлтийн аль тохирохыг хэрэглэх нөхцөлөөр) үүргийг хүлээнэ. Үүнтэй холбоотойгоор Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжих боломжтой Нэмэгдсэн Өртгийн албан татварын хөнгөлөлт болон буцаан олголтын өргөдлийг мэдүүлж, үүний бүхий л үр ашгийг хүртэхийн төлөө хүчин чармайлт гаргана.
- Үйлчилгээ үзүүлэгч нь бараа материал эсхүл түүний орцод (хэрэв байгаа бол) ногдуулсан импортын гаалийн татварийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэхээр бол энэ талаар Компанитай зөвлөлдөн хамтран ажиллаж боломжийг хайх ба үүний төлөө өөрийн хүчин чармайлт гаргана. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх үүрэгтэй бүх татвар нь Гэрээний үнэд багтсан байх ба Гэрээний үнэ дээр нэмэгдэхгүй.
- Дор дурдсан 14.1(б)(iii)-т зааснаар Компани нь энэхүү Гэрээнд заасан Үйлчилгээний гүйцэтгэлтэй (эсхүл аливаа барааны хүргэлт) холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий байгууллагаас тогтоосон эсхүл ногдуулсан дараахь төрлийн татваруудыг төлөх үүрэг хүлээнэ. Үүнд:
- (d) Компанийн хүсэлтийг бичгээр хүлээж авмагц Үйлчилгээ үзүүлэгч нь Компанид дор дурдсан мэдээллийг хүргүүлнэ. Үүнд:
- (i) Аль нэг Засгийн газрын агетлагаас Компанийн татвар төлөлтийн талаар мэдээлэл авах хүсэлтэд нийцүүлэн бүх мэдээлэл, шаардагдах маягтуудыг байгууллагын бүртгэлийн гэрчилгээ ба НӨАТ-ын бүртгэлийн гэрчилгээний хамт;
 - (ii) Худалдааны нэхэмжлэхийг Компанийн тавьсан шаардлагыг хангасан хэлбэр, маягтын дагуу;
 - (iii) Монгол Улсын НӨАТ-ын баримт бичгийг Монгол улсын НӨАТ-ын тухай хуульд заасан шаардлагад нийцүүлж, зохих маягтын дагуу;
- (e) Үйлчилгээ үзүүлэгч эсхүл аливаа туслан гүйцэтгэгчийн Татварын тухай хуулинд холбогдох хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас үүссэн аливаа болон бүх хүлээх хариуцлага, нэхэмжлэл шаардлага, хохирол, зардлаас (өмгөөлөгчийн төлбөр, торгууль, шийтгэл, алданги зэргийг багтаана) Компанийг чөлөөлөх ба түүнийг компанид нөхөн төлөх, компанийг эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.
- (f) Үйлчилгээ үзүүлэгч нь Монголд Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж тул Гэрээнд Компани нь Үйлчилгээ үзүүлэгчийг орон байр, хоол хүнсээр болон нислэгийн зардлыг хангана гэж тусгасныг хүлээн зөвшөөрч буй бол,

- (i) Компани тухайн орон байр, хоол хүнс, нислэгийн НӨАТ-ийг багтаасан зардлын дүнд ногдох Худалдааны нэхэмжлэх гарган Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ;
- (ii) Компаниас ирүүлсэн нэхэмжлэхийн дүнтэй тэнцүү дүнгээр Үйлчилгээ үзүүлэгч Компанид Худалдааны нэхэмжлэх гаргаж болно.

12. Гаалийн ба онцгой албан татвар

- (a) Компани Холбогдох бараа бүтээгдэхүүнийг худалдан авахаар сонгосон бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь түүнийг импортлогч бол Үйлчилгээ үзүүлэгч нь:
 - (i) аль нэг Засгийн газрын эрх бүхий байгууллагаас ногдуулсан эсхүл түүнд төлөх шаардлагатай бүх гаалийн татвар мөн бусад аливаа гадаад тээвэрлэлтийн зардлын төлбөрийг хариуцна.
 - (ii) Хоёр талт чөлөөт худалдааны гэрээг (эсхүл түүнтэй дүйх) хэрэглэх буюу түүгээр үл хязгаарлагдах бусад замаар гаалийн татваргүйгээр Холбогдох бараа бүтээгдэхүүнийг импортлох бүхий л хүчин чармайлтыг гаргана.
- (b) Ашиглаж буй тээвэрлэлтийн нөхцөлөөс үл хамааран Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн хүсэлтээр гаалийн татварын хөнгөлөлтийн тохиролцоо эсхүл Хоёр талт чөлөөт худалдааны гэрээний (эсхүл түүнтэй дүйх) дагуу өргөдөл гаргах болон гэрчилгээ авахтай холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг мөрдөхөд шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичгээр Компанийг хангана. Компанийн гаргасан тухайн өргөдөл амжилттай шийдвэрлэгдсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Гаалийн татварын буцаан олголтыг авах ба гаалийн татварын аливаа хэмнэлтийг Компанид шилжүүлнэ.
- (c) Ашиглаж буй тээвэрлэлтийн нөхцөлөөс үл хамааран Үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох тээвэр зуучийн компанийг Холбогдох бараа бүтээгдэхүүнийг хүргэхээс өмнө Компаниас шаардах бүх баримт бичгээр хангах үүрэгтэй. Компани тээврийн зардлыг хариуцаж буй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь баримт бичгийн бүрдэл дутуу эсхүл алдаатай байгаа тохиолдолд Компанийн тээвэр зуучийн компани Холбогдох бараа бүтээгдэхүүнийг хүлээн авахаас татгалзаж болохыг, мөн түүнчлэн баримт бичиг бүрэн гүйцэд бөгөөд алдаагүй зөв болох хүртэл Холбогдох бараа бүтээгдэхүүнийг хүргэгдсэнд тооцохгүй болохыг хүлээн зөвшөөрнө.

13. Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөр

13.1 Төлбөрийн хэлбэр

Гэрээнд өөрөөр заагаагүй бол, Компаниас Үйлчилгээ үзүүлэгчид Үйлчилгээний гүйцэтгэлтэй холбоотойгоор Гэрээний дагуу хийх бүх төлбөр нь Үйлчилгээ үзүүлэгчийн өгсөн банкны данс уруу цахим шилжүүлгийн аргаар буюу бэлэн бус хэлбэрээр, Худалдан авах захиалгад заасан валютаар хийгдэнэ.

13.2 Худалдааны нэхэмжлэх

- (a) Компанитай тусгайлан зөвшилцсөнөөс бусад тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон гарах Худалдааны нэхэмжлэхийг гэрээний хэрэгжих хугацааны туршид сар бүрийн эцэст Үйлчилгээ үзүүлэх болон Холбогдох бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх Худалдан авах захиалгад заасан жишгээр үнэ, төлбөр болон бусад мөнгөн дүнг тооцоолж Компанид хүргүүлэх ёстой.
- (b) Худалдааны нэхэмжлэх нь Компанийн хүлээн зөвшөөрсөн маягтын дагуу байх бөгөөд дор дурдсан мэдээллийг агуулсан байх ёстой. Үүнд:
 - (i) Худалдааны нэхэмжлэхийн холбогдож буй Худалдан авах захиалгын дугаар;
 - (ii) Худалдааны нэхэмжлэхийн хамарч буй хугацаанд гүйцэтгэсэн Үйлчилгээний товч тодорхойлолт;
 - (iii) Худалдааны нэхэмжлэлтэй холбоотой Компанийн шаардсан үндэслэл бүхий аливаа хяналт, нэмэлт баталгаа болон баримт бичиг зэрэг болно.

13.3 Худалдааны нэхэмжлэхийн төлбөр

Компани нь 13.4, 14, 25.8(e)(i) ба 28.2(b)-д заасны дагуу Төлбөр Төлөх Өдөр Худалдааны нэхэмжлэхэд заасан мөнгөн дүнг Үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой.

13.4 Маргаан бүхий худалдааны нэхэмжлэх

Хэрэв Компани нь Худалдааны нэхэмжлэхэд дурдсан аль нэг мөнгөн дүнг маргаантай гэж үзвэл энэ тухайгаа Үйлчилгээ үзүүлэгчид Худалдааны нэхэмжлэх хүлээн авснаас хойш 21 өдрийн дотор мэдэгдэх ёстой ба 13.3-д заасны дагуу хүлээн зөвшөөрч буй аливаа мөнгөн дүнг төлөх шаардлагатай бөгөөд хэрэв маргаан бүхий худалдааны нэхэмжлэхийн дагуу Компани төлбөр төлсөн тохиолдолд Компанийг уг төлбөрийн дүнг эсхүл түүнийг төлөх хариуцлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцохгүй.

13.5 Нэхэмжлэхийн алдаа ба онцгой тохиолдол

13.3-д зааснаар үл хязгаарлагдан, хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээний нэхэмжлэхтэй холбоотойгоор ямар нэг алдаа болон онцгой тохиолдлыг олж илрүүлэх эсхүл энэ тухай сануулга авсан тохиолдолд түүнийг Үйлчилгээ үзүүлэгч ба Компани хамтран хэлэлцэж, шаардлагатай бол Үйлчилгээ үзүүлэгч нь яаралтай засах арга хэмжээ авч тухайн нэхэмжлэхэд өөрчлөлт оруулах эсхүл илүүдэл төлбөрийг буцаан олгоно.

14. Төлбөрийн суутгал

14.1 Суутгал тооцох

Компани нь:

- (a) 13.3-д заасны дагуу Үйлчилгээ Үзүүлэгчид төлөх ёстой эсхүл төлөхөөр болсон аливаа төлбөрөөс дараахь дүнгээр (Мөн 14 зүйлийн дагуу төлөх ёстой хасалттай холбоотойгоор Шууд бус гүйлгээний татварыг оролцуулан) хасалт хийж болно. Үүнд:
 - (i) Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтнаас Компанид төлөх ёстой бүх өр төлбөр ба мөнгөн дүн;
 - (ii) Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтны хариуцах, Компанид төлөх эсхүл буцаан олгох ёстой хариуцлага болон төлбөрийг Компани хүлээсэн, төлсөнтэй холбоотой бүх төлбөрийн дүн (Гэрээнд заасны дагуу аливаа нөхөн төлбөрийг оролцуулан);
 - (iii) Компанийн хүлээн зөвшөөрөх стандартаас доогуур Үйлчилгээний гүйцэтгэл эсхүл Холбогдох бараа бүтээгдэхүүний эвдрэл гэмтлийг нөхөх зардлын дүн; түүнчлэн
- (b) Энэхүү Гэрээнд заасан Компанийн эрхийг хөндөхгүйгээр, хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээгээр хүлээсэн аль нэг үүргээ гүйцэтгээгүй бол тухайн асуудлыг бүрэн засч залруулах хүртэл Гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчид төлбөл зохих төлбөрөөс хэсэгчилэн эсхүл бүхэлд нь мэдэгдэл хүргүүлэхгүйгээр суутгаж болно.

14.2 Хуулийн дагуух суутгал, хасалт

- (a) Хэрэв Компани нь хуульд заасан шаардлагын дагуу Гэрээний дагуу төлөх ёстой үнийн дүнгээс ямар нэг хэмжээг (Суутгасан дүн) суутгах, хасах тохиолдолд тухайн суутгах эсхүл хасалт хийсэн хэмжээний төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлсөн гэж тооцогдох бөгөөд Компани нь Суутгасан дүнгийн тооцооноос Үйлчилгээ үзүүлэгчид ямар нэгэн төлбөр төлөх хариуцлагыг хүлээхгүй.
- (b) Хэрэв Компани нь Суутгасан дүнг төлөхөөс зохих ёсоор суутгаагүй эсхүл хасалт хийгээгүй бол дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Үүнд:
 - (i) Хасалт хийсэн дүнтэй тэнцүү хэмжээний төлбөрийг шаардсан мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид өгөх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор уг төлбөрийг Компанид төлнө;
 - (ii) Компаниас Үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой аливаа мөнгөн дүнгээс хасалт хийсэн дүнтэй тэнцүү хэмжээг хасч болох бөгөөд ийнхүү хассан хэмжээний төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлөгдсөн гэж тооцох бөгөөд хасалт хийсэн дүнгийн тооцооноос ямар нэг хэмжээг Үйлчилгээ үзүүлэгчид төлөх хариуцлагыг Компани хүлээхгүй; эсхүл
 - (iii) 14.2.(b)(i)-д заасан шаардлага болон 14.2.(b)(ii)-д заасан хэмжээгээр хийх суутгал, хасалтыг хамтад нь Суутгасан дүнд тусгаж болох бөгөөд,

дээрх тохиолдол бүрийн хувьд Үйлчилгээ үзүүлэгчийн аливаа үйлдэл, эс үйлдэхүй болон санамсаргүй байдлын улмаас Суутгасан дүнг төлөхөөс зохих ёсоор татгалзаагүй эсхүл хасалт хийгээгүй бөгөөд Суутгасан дүнтэй холбоотойгоор Компанийн төлбөл зохих аливаа торгууль, шийтгэл эсхүл хүүг Суутгасан дүнд оруулж тооцно.

14.3 Суутгал, хасалт тооцох тухай мэдэгдэх

Компани нь суутгал эсхүл хасалт хийсэн аливаа дүн хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгчид 14.1 ба 14.2-д заасны дагуу мэдэгдэх ёстой.

15. Худалдан авалтын доод хэмжээ байхгүй ба онцгой эрх олгохгүй байх

15.1 Худалдан авалтын доод хэмжээ байхгүй байх

Үйлчилгээ үзүүлэгчээс авах Үйлчилгээний доод түвшинг шаардах букуу худалдан авах үүргийг Компанид хүлээлгэсэн тухай Гэрээний аль ч хэсэгт заагаагүй болно.

15.2 Онцгой эрх олгохгүй байх

Гэрээ нь Үйлчилгээтэй (эсхүл түүний аль нэг хэсэгт) холбоотойгоор Компани ба Үйлчилгээ үзүүлэгчийн хооронд онцгой эрх бүхий харилцаа үүссэнийг нотлох үндэслэл биш бөгөөд мөн ийм харилцааг үүсгэхгүй.

16. Үйлчилгээ үзүүлэгчийн ажиллах хүч

16.1 Үйлчилгээ үзүүлэгчийн ажиллах хүч

Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээг чанартай гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгцээтэй бүх ажилтныг ажиллуулах шаардлагатай. Тухайн ажилтан нь холбогдох чадварын шаардлага хангасан, өрсөлдөх чадвар бүхий, өөрийн ажиллаж буй Үйлчилгээний холбогдох хэсгийг гүйцэтгэх чадвартай байх ёстой.

16.2 Ажиллах хүчний тохиролцоо

Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээний аливаа хэсгийг гүйцэтгэхэд оролцож буй Үйлчилгээ үзүүлэгчийн бүх ажилтан нь Нууц мэдээлэл ба Оюуны өмчийн эрхийн талаар заасан 30 ба 32-т заасан зохицуулалтыг мөрдөж ажиллана гэдгийг баталгаажуулах ёстой.

16.3 Компани ажилтнуудаас татгалзах

Компани нь Үйлчилгээ үзүүлэгчийн аливаа ажилтныг зохих туршлага, чадварын хувьд дутмаг, хууль бус үйл ажиллагаанд оролцсон, өрсөлдөх чадваргүй эсхүл хайхрамжгүй байдал гаргасан тохиолдолд Компанийн төлөөлөгчийн саналаар ажиллуулахаас татгалзаж болно. Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн төлөөлөгчөөс тухайн ажилтныг ажлаас халах, түүнчлэн Компанийн төлөөлөгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Үйлчилгээтэй холбоотойгоор дахин ажилд авч ажиллуулахгүй байхыг шаардсан мэдэгдлийг хүлээн авмагц түүний дагуу уг ажилтныг солих ёстой. Түүнчлэн, Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн халагдсан ажилтны оронд зохих чадварын шаардлага хангасан, өрсөлдөх чадвар бүхий, дадлага туршлагатай, зөвшөөрөгдсөн ажилтныг өөрийн зардлаар сольж ажиллуулах ёстой.

16.4 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага

- (a) Гэрээнд тусгайлан өөрөөр заагаагүй бол Үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох Үйлчилгээг (хэрэв хамаарах бол) гүйцэтгэх Ажилчиддаа шаардлагатай виз, ажлын зөвшөөрөл олгох үүрэгтэй.
- (b) 26-д заасныг үл хязгаарлан Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох хуулийн дагуу Ажилчид ажиллуулахтай холбогдсон бүх төлбөрийг Монголын засгийн газарт төлөх үүрэгтэй. Үүнд Нийгмийн даатгалын тухай Монгол улсын хуулийн дагуу төлөх шаардлагатай бүх Нийгмийн даатгалын төлбөр багтах ба түүгээр үл хязгаарлагдана.
- (c) Хэрэв хамааралтай бол Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүрэг хүлээнэ:
 - (i) энэхүү Гэрээний дагуу аливаа Үйлчилгээг үзүүлэхэд Үйлчилгээ үзүүлэгч шаардлагатай бүх хүн хүч, хяналт, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны хэрэгсэл болон бусад шаардлагаар хангах,
 - (ii) өөрийн ажилтнуудын Сайт дээр ажиллах үед хөдөлгөөнд оролцоход хэрэглэгдэх бүх автомашин, (хэрэв хамааралтай бол) жолооч нар нь зохих журмаар зөвшөөрөл авсан байх ёстой бөгөөд бүх машин нь холбогдох замын аюулгүй байдал, замын хөдөлгөөний хууль, дүрэм, зохицуулалтыг дагаж мөрдөх ёстойг;
 - (iii) Өөрийн ажилтны эрүүл мэнд ба аюулгүй байдлыг хариуцаж ажиллана.

17. Бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, ачилт, тээвэрлэлт

17.1 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага

Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол, Төслийн талбай хүртэлх тээвэрлэлтийг өөрийн зардлаар хариуцна.

17.2 Тээвэрлэлтийг Компани хариуцах

Гэрээний нөхцөлийн дагуу Компани нь Холбогдох бараа бүтээгдэхүүний зарим эсхүл бүх хэсгийн тээвэрлэлтийг хариуцах үүрэг хүлээсэн бол, Үйлчилгээ үзүүлэгч нь ачихад бэлэн болсон Холбогдох бараа бүтээгдэхүүний тухай дэлгэрэнгүй мэдээллийг тээвэрлэлтийн зохицуулалт хийх хангалттай цаг хугацааны өмнө Компанийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

17.3 Тээвэрлэлтийн бэлтгэл

Үйлчилгээ үзүүлэгч нь Холбогдох барааг Төслийн талбай хүртэл тээвэрлэхдээ тохирох тээврийн нөхцөлийг дамжин өнгөрөх цаг агаарын онцлог байдалд нийцүүлэн Компанийн өгсөн бүх зааварчилгаа, тэргүүний туршлагын дагуу ачихад бэлэн болсон бүх Барааны савлалт, баглаа боодол, хамгаалалтыг сайтар хийх ёстой. Үйлчилгээ үзүүлэгч нь

тээвэрлэлтэнд яваа буюу дамжин өнгөрөх Холбогдох бараа бүтээгдэхүүнийг ачих, буулгахад шаардлагатай бүхий л багаж, тоног төхөөрөмжөөр хангах зохицуулалтыг хийх ёстой.

17.4 Илгээсэн/ачсан өдрийг мэдэгдэх

Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн төлөөлөгчид бараа тус бүрийн илгээсэн/ачсан өдөр ба Төслийн талбайд очихоор тооцоолсон өдрийг тухай бүрт мэдэгдэх ёстой.

18. Хяналт шалгалт

18.1 Хяналт шалгалт

Компанийн төлөөлөгч нь аливаа Холбогдох бараа бүтээгдэхүүнийг Гэрээний дагуу шаардлага хангаж байгаа болон Гэрээнд заасан стандартад нийцсэн эсэхийг тодорхойлохын тулд хэдийд ч хянан шалгах эрхтэй байна.

18.2 Мэдээллээр хангах үүрэг

Үйлчилгээ үзүүлэгч нь Компанид ямагт Холбогдох бараа бүтээгдэхүүнд хяналт тавих эрхийг олгох ёстой бөгөөд Сайт дээр байгаа, хаа нэгтээ хадгалагдсан эсхүл үйлдвэрлэлийн явцад байгаа бүх Холбогдох бараа бүтээгдэхүүний хяналт, шалгалт, туршилт хийхэд шаардлагатай бүхий л бололцоогоор хангах ёстой.

18.3 Хяналт шалгалтын зардал

(a) 18.3(b)-д заасан нөхцөлд хамааралтайгаар, хэрэв Компанийн төлөөлөгч Холбогдох бараа бүтээгдэхүүний аливаа хэсгийг буулгах эсхүл задалж угсрах удирдамж өгсний дараа шалгалт шинжилгээ хийх явцад уг Холбогдох бараа бүтээгдэхүүнийг Гэрээний дагуу шалгасан бол буулгах эсхүл задлах, буцаан эвлүүлэхэд гарах бүх зардлыг Компани хариуцна. Хэрэв Холбогдох бараа бүтээгдэхүүн нь Гэрээний дагуу биш байгаа нь тогтоогдвол уг Дагалдах барааг Гэрээний дагуу нөхцөлд нийцүүлэхтэй холбоотой аливаа зардлаар үл хязгаарлагдан гарах бүх зардлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

(b) Хэрэв Компанийн төлөөлөгч Үйлчилгээ үзүүлэгчид Холбогдох бараа бүтээгдэхүүнийг угсрахаас өмнө түүний аль нэг хэсэгт Компанийн төлөөлөгч үзлэг шалгалт хийх тухай холбогдох мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид өгсөн бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн төлөөлөгчид үзлэг шалгалт хийх нөхцөл боломжийг эхлэн олгохгүйгээр Холбогдох бараа бүтээгдэхүүнийг угсарвал, түүнийг задалсны болон дахин угсарсны улмаас гарах аливаа зардлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

19. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутаг

19.1 Заалтын хэрэглээ

Энэхүү 19 дугаар заалт нь Үйлчилгээ үзүүлэх зорилгоор Сайтад эсхүл түүний эргэн тойронд ойрхон байх шаардлагатай Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтанд үйлчилнэ.

19.2 Үйлчилгээ үзүүлэгч баталгаа гаргах

Үйлчилгээ үзүүлэгчийн ЭМААБООН-ийн шаардлага хангасан гүйцэтгэл болон Компанийн бизнесийн амжилт нь хоорондоо шууд холбоотой гэдгийг Үйлчилгээ үзүүлэгч нь хүлээн зөвшөөрнө.

19.3 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутагтай холбоотой хууль тогтоомж, бодлого шийдвэр, холбогдох стандартыг дагаж мөрдөх

Үйлчилгээ үзүүлэгч нь:

(a) 22 дүгээр заалтыг үл хязгаарлан байнга сахин мөрдөх шаардлагатай Компанийн ЭМААБООН-ийн бодлого болон дагалдах стандартууд (нэг хувийг Үйлчилгээ үзүүлэгчид өгсөн) (ЭМААБООН-ийн бодлого, стандарт);

(b) 23 дугаар заалтыг үл хязгаарлан, цаг тухай бүрт батлагдсан ЭМААБООН-ийн талаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүх холбогдох хууль тогтоомжууд;

(c) 19 дугаар заалтад агуулсан ЭМААБООН-ийн нөхцөлүүдийг

(d) батлагдсан ЭМААБООН-ийн Удирдлагын төлөвлөгөөг

тус тус дагаж мөрдөх, мөн өөрийн ажилтнуудаар нэгэн адил мөрдүүлэхийг хангахыг хүлээн зөвшөөрнө.

19.4 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутгийн удирдлагын төлөвлөгөө

(a) Хэрэв ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөг (**ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөө**) Үйлчилгээ үзүүлэгчийн Тендерийн (хэрэв байгаа бол) нэг хэсэг болгож ирүүлээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээг байгуулсанаас хойш 30 хоногийн дотор, ЭМААБООН-ийн бодлого, стандартын дагуу санал болгож буй ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөгөөг Компанийн төлөөлөгчид хянуулахаар хүргүүлэх ёстой.

(b) Компанийн төлөөлөгч нь санал болгож буй ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөг хянасны үндсэн дээр аливаа нэмэлт өөрчлөлт хийх тухай хүсэлтийг Ажлын 10 хоногийн дотор Үйлчилгээ үзүүлэгчид

гаргаж өгнө. Үйлчилгээ үзүүлэгч нь Компаниас нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүлээн авснаас хойш Ажлын 3 хоногт Компанийн төлөөлөгчийн санал болгосон нэмэлт өөрчлөлтийг ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөнд оруулж, дахин танилцуулна.

- (c) ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөө ба түүнд оруулахыг хүссэн нэмэлт өөрчлөлтийг Компанийн төлөөлөгч батлах хүртэл буюу зөвшөөрөхөөс өмнө Компани Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтныг Сайт дээр ажиллахыг түдгэлзүүлж, эсвэл хориглож болно..
- (d) Компанийн төлөөлөгч нь холбогдох ЭМААБООН-ийн хууль тогтоомж, ЭМААБООН-ийн бодлого, стандартад орсон аливаа харгалзах нэмэлт өөрчлөлтийг өмнө нь баталсан ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөнд оруулах талаар Үйлчилгээ үзүүлэгчид байнгын чиглэл, удирдамж өгч болно.
- (e) Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ хэрэгжих хугацааны туршид батлагдсан ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөний хувийг Сайт дахь албан ёроонд эсхүл ажиллах талбартаа хадгалах ёстой.

19.5 Танилцуулах сургалт

- (a) Компаниас шаардсан холбогдох бүхий л удиртгал сургалтанд (Компанийн танилцуулах сургалт) Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтан бүр хамрагдах ёстой.
- (b) Компанийн үйл ажиллагааны зарим онцлог хэсэгт мөрдөгдөх дүрэмд нийцүүлэн Үйлчилгээ үзүүлэгчийн аливаа ажилтан нь Үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах тодорхой ур чадвартай (**Компаниас шаардсан чадвар**) байх ёстой ба Компаниас эрх хэмжээтэй холбоотой удиртгал болон сургалт нь дараахь шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:
 - (i) ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөнд багтсан байх;
 - (ii) тэдгээрийг Техникийн шаардлага, Тодорхойлолтонд заагаагүй тохиолдолд Компанийн төлөөлөгчөөр зөвшөөрөгдсөн байх;
 - (iii) Аливаа ажил эхлэхээс өмнө холбогдох ажилтнаар Сайтad эсхүл түүний ойролцоо явагдсан байх ёстой зэрэг болно.
- (c) Өөрөөр тохиролцоогүй тохиолдолд:
 - (i) Компани нь Компанийн удиртгал сургалтыг зохион байгуулж, санхүүжүүлэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтны Компанийн удиртгал сургалтанд оролцох зардлыг хариуцна;
 - (ii) Үйлчилгээ үзүүлэгч нь Компаниас шаардсан чадвартай холбоотой бүх сургалтыг зохион байгуулж, санхүүжүүлэх бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтны уг сургалтанд оролцох зардлыг хариуцна.
- (d) Үйлчилгээ үзүүлэгч нь ХАБЭА-н тухай хуульд заасан шаардлагын дагуу өөрийн зардлаар Ажилтнууддаа сургалт зохион байгуулж, хамруулах шаардлагатай бөгөөд Ажилтнууддаа хамруулсан сургалтын талаарх бүх бүртгэлийг (шалгалтын дүн гэх мэт) ажлын байр дээр хадгалах үүрэгтэй.
- (e) Сайтad ажиллаж буй Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтантай уулзахаар ирсэн, аливаа биеийн хөдөлмөрийн ажилд оролцохгүй хүн бүр Компанийн холбогдох удиртгал сургалтад хамрагдах шаардлагатай. Гэвч уг зочны Сайтad байх бүх хугацаанд Компанийн холбогдох удиртгал сургалтанд бүрэн хамрагдсан, Сайтad нэвтрэн орохтой холбоотой Компанийн шаардсан чадвар бүхий хэн нэгэн хамт яваа бол дээрх шаардлага үйлчлэхгүй.

19.6 Үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага

Энэхүү 19 дугаар заалтын аль ч нөхцөл нь (ЭМААБООН-ийн удирдлагын төлөвлөгөөний зөвшөөрлийг оролцуулан) өөрийн аливаа ажилтны эрүүл мэнд ба аюулгүй ажиллагааг баталгаажуулахгүй бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтанд ногдох аливаа үүрэг хариуцлагыг хязгаарлах эсхүл чөлөөлөх үндэслэл болгохгүй. Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн ажилтнуудын эрүүл мэнд ба аюулгүй байдлыг гэрээ хэрэгжих бүхий л хугацаанд дангаараа хариуцна гэдгийг хүлээн зөвшөөрнө.

20. Үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэлд аудит хийх эрх

20.1 Аудит

Үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилчид нь Үйлчилгээ үзүүлэгчийн ажлын талбай, баримт бичиг, мэдээ мэдээлэлд (цахим хэлбэрээр хадгалсан баримт бичгийн хамт) нэвтрэх зөвшөөрлийг Компанид олгож, Үйлчилгээ үзүүлэгч дараах баримт бичгийг дагаж мөрдөж буй эсэхийг Компанийн ажилтан баталгаажуулах, хянан шалгах болон аудит хийх үүднээс Үйлчилгээ үзүүлэгчийн ажилчдаас Үйлчилгээтэй холбогдуулан ярилцлага авах зөвшөөрөл олгоно. Үүнд:

- (a) ЭМААБООН-ийн Удирдлагын төлөвлөгөө болон 19-д заасан ЭМААБООН-ийн нөхцөл.
- (b) 22-т заасан Компанийн бодлого.

20.2 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс авах арга хэмжээ

Үйлчилгээ үзүүлэгч 20.1-д заасан нөхцөл, бодлого, стандартыг үл биелүүлээгүйн улмаас Компанийн эдлэх аливаа бусад эрх, засч залруулах арга хэмжээг үл хязгаарлан, 20.1-д заасан аудитаар аливаа зөрчил илэрсэн тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч даруй түүнийг засч залруулах арга хэмжээ авч, авсан арга хэмжээний талаар Компанид мэдэгдэнэ.

21. Сайтад нэвтрэн орох

21.1 Нэвтрэх эрх

25.8 (е) ба 21-д зааснаар үл хязгаарлагдан, Компани нь Үйлчилгээ үзүүлэгчид Гэрээ хэрэгжих өдрөөс эхлэн Сайтад нэвтрэх эрхийг албан ёсоор олгох бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь Сайтад Үйлчилгээг эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Компанийн төлөөлөгчид энэ тухай мэдэгдэл хүргүүлнэ.

21.2 Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг

(a) Сайтад Үйлчилгээг эхлэхээс өмнө Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн баримтлах ажлын цаг, үргэлжлэх хугацааг Компанийн төлөөлөгчид мэдэгдэх ёстой бөгөөд хэрэв тухайн ажлын цаг, үргэлжлэх хугацаанд ямар нэгэн өөрчлөлт оруулах бол энэ тухай Компанийн төлөөлөгчид 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэх ёстой.

(b) Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн үйл ажиллагаанд саад болох магадлалтай аливаа ажиллагааны талаар тухай бүрт Компанийн төлөөлөгчтэй зөвлөлдөх ёстой бөгөөд 14 хоногийн өмнө бичгээр зөвшөөрөл авна. Компанийн төлөөлөгч нь энэ тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хариу өгөх ёстой.

21.3 Сайтад Нэвтрэх эрх олгохоос татгалзах эрх ба Сайтаас гаргах

Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтан нь 18, 21-д заасан аливаа шаардлагыг биелүүлээгүй бол Компанийн төлөөлөгч нь өөрийн үзэмжээр:

- (a) тухайн хүн буюу хүмүүсийг Сайтад нэвтрэхийг хориглох эсхүл зөвшөөрөх шийдвэрийн аль нэгийг холбогдох нөхцөл шаардлагад нийцүүлэн гаргах ба/буюу
- (b) Үйлчилгээ үзүүлэгч ба/эсхүл түүний Ажилчдыг аливаа материал, бодисыг Сайтаас өөрийн зардлаар гаргахыг шаардах эрхтэй.

Мөн Үйлчилгээ үзүүлэгч нь уг шаардлагыг өөрийн зардлаар даруй биелүүлж, бүх ажил, ажилтан болон байгаль орчныг хамгаалж, аюулгүй байдлыг хангах бүх боломжит арга хэмжээг авах ёстой.

21.4 Эзэмших онцгой эрх байхгүй байх

Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний аль ч хэсэгт Сайтад нэвтрэх онцгой эрх олгох тухай байхгүй бөгөөд зөвхөн Үйлчилгээг үзүүлэхтэй холбоотойгоор Компанийн төлөөлөгчийн шаардлагатай гэж үзсэн зөвшөөрөгдөх хэмжээнд Сайтад нэвтрэх ажиллах боломжтойг баталгаажуулсан явдал гэдгийн хүлээн зөвшөөрнө.

22. Компанийн бодлогод нийцүүлэх

22.1 “Оюу толгой” ХХК-ийн бодлого

Гэрээ хэрэгжих хугацааны туршид Үйлчилгээ үзүүлэгчнээс Компаниас Үйлчилгээ үзүүлэгчид цаг тухай бүрт бичгээр мэдэгдсэн Компанийн болон Рио Тинто Группийн дүрэм, журам, бодлого тус бүрийг мөрдөн ажиллах ёстой бөгөөд түүний ажилтнууд нэгэн адил мөрдөн ажиллаж байхыг хангана.

22.2 Рио Тинтогийн бизнесийн үйл ажиллагааны туршлага, стандартууд

Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний үүргийг гүйцэтгэхдээ доорх шаардлагыг дагаж мөрдөх буюу Ажилтнуудаараа дагаж мөрдүүлнэ:

- (a) “Бидний ажлын арга барил”, “Ханган нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм” болон “Бизнесийн ёс зүйн стандарт” (хамтад нь “**Рио тинтогийн бизнесийн үйл ажиллагааны туршлага, стандарт**” гэх) гэсэн Рио Тинто Группын бодлогыг дагаж мөрдөх, түүнд нийцүүлэн ажиллах. Уг баримт бичгийг <http://www.riotinto.com/aboutus/policies-standards-and-guidance-5243.aspx> гэсэн холбоосоор орж үзэх боломжтой
- (b) Үйлчилгээ үзүүлэгчийн ажлын байр, аливаа баримт бичиг, өгөгдөлд (цахим хэлбэрээр хадгалсан баримт үүнд хамаарна) нэвтрэх эрхийг Компанид өгөх, Рио Тинтогийн бизнесийн үйл ажиллагааны туршлага, стандартыг мөрдөж, хэрэгжүүлж байгаа байдалд Компанийн ажилтан хяналт тавих, баталгаажуулах, аудит шалгалт хийхэд Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтнуудаас Үйлчилгээтэй холбоотойгоор ярилцлага авахыг зөвшөөрөх
- (c) Рио тинтогийн бизнесийн үйл ажиллагааны туршлага, стандартыг бодитой зөрчсөн, зөрчсөн болох нь батлагдсан, зөрчсөн байж блдзошгүй сэжиг бүхий үйлдлийг Компанид мэдэгдэх, эсхүл Рио Тинто Группын Спийк-АУТ хөтөлбөрөөр дамжуулан мэдэгдэх;

- (d) Рио тинтогийн бизнесийн үйл ажиллагааны туршлага, стандартыг зөрчсөн нь батлагдсан эсхүл зөрчсөн байж болзошгүй сэжиг бүхий үйлдлийг хянан шалгахад Компанитай шуурхай бөгөөд бүрэн хамтарч ажиллах.

23. Хууль

23.1 Хууль тогтоомжид нийцүүлэх

Гэрээ хэрэгжих хугацааны туршид Үйлчилгээ үзүүлэгч нь:

- (a) Энэхүү гэрээнд заасан үүрэгт холбогдох бүх тогтоомж, Засгийн газрын эрх бүхий байгууллагын гаргасан шаардлагыг мөрдөх ёстой ба Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтнууд нэгэн адил мөрдөн ажиллах явдлыг хангах;
- (b) Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор, өөрийн зардлаар:
- (i) Шаардлагатай бүх мэдэгдлийг хүлээн авах;
- (ii) Шаардлагатай бүх мэдэгдлийг өгөх;
- (iii) Шаардлагатай бүх төлбөр, өр төлбөр ба татвар хураамжийг төлөх

ёстой бөгөөд хэрэв Компани хүсэлт гаргавал 23.1(б)-д дурдсан ажиллагааны талаар нотолгоог хангах ёстой.

23.2 Хууль зөрчсөнөөс үүсэх үр дагавар

- (a) Үйлчилгээ үзүүлэгч нь 19, 22, 23 дугаар заалтыг биелүүлээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч энэ тухайгаа нэн даруй Компанид мэдэгдэнэ гэдэгтэй санал нийлнэ.
- (b) Энэхүү Гэрээнд заасан бусад үр дагавраас гадна 19, 22, 23-р заалтыг зөрчсөнийг Компани гэрээний зөрчил гэж үзэх бөгөөд гэрээний үүргээ биелүүлээгүй/зөрчсөн тохиолдолд Гэрээгээр эдлэх эрхээ эдлэх ба үүнд Гэрээнд заасан аливаа хүлээлгийн болон зөрчил арилгах хугацааг авч үзэхгүй.

24. Давагдашгүй хүчин зүйлс

24.1 Давагдашгүй хүчин зүйлсийг мэдэгдэх

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас гэрээний аль нэг тал хугацаа хоцрох эсхүл гэрээгээр хүлээсэн аливаа үүргийг (мөнгөн төлбөр төлөх үүргээс бусад) биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь нөлөөлж байгаа энэхүү нөхцөл байдал үүссэнээс хойш нөгөө талдаа 24.2-д заасан шаардлагын дагуу мэдэгдлийг аль болох хурдан хүргүүлнэ.

24.2 Давагдашгүй хүчин зүйлс бий болсон тухай мэдэгдэл

24.1-д зааснаар хүргүүлэх мэдэгдэлд:

- (a) гэрээний нэг талын гүйцэтгэж чадахгүй байгаа үүргийг заах;
- (b) тухайн давагдашгүй хүчин зүйлийг бүрэн тодорхойлох;
- (c) (в) тухайн давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацааг тооцоолох;
- (d) тухайн нөхцөл байдлыг засч залруулах, намжаахаар санал болгож буй арга хэмжээний талаар тодорхой тусгах ёстой.

24.3 Хохирлыг арилгах, засч залруулах үүрэг

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг хойшлуулж буй гэрээний аль нэг тал нь:

- (a) Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас учирсан хохирлыг боломжит хэмжээгээр барагдуулж, үүргийн биелэлтийг аль болох хурдан хангуулах;
- (b) нөгөө талд гэрээний дагуу үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хариуцлагыг бууруулах боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

25. Даатгал

25.1 Үйлчилгээ үзүүлэгчийн даатгалууд

Гэрээний хугацаанд болоод гэрээнд заасан аливаа нэмэлт хугацаанд Гэрээний гүйцэтгэлээс үүссэн эсхүл эсхүл үүсч болох аливаа эрсдэл, тохиолдолтой холбогдон 25.2, 25.3, 25.4, 25.5, 25.6, 25.7-д заасан холбогдох даатгалд (*Үйлчилгээ үзүүлэгчийн даатгал*) өөрийн зардлаар хамрагдаж, хэрэгжүүлнэ.

25.2 Ерөнхий болон бүтээгдэхүүний хариуцлагын даатгал

- (a) Тухайн тохиолдол гарах үед үйлчилгээ болон дагалдангийн гэрээний дагуу даатгуулагчийн үйлчилгээнд оролцож дор ажиллаж байсан хүнээс өөр бусад хүнд учирсан осол гэмтэл эсхүл амь насны хохирол, эсхүл даатгуулагчид хамаарах, түүний хараа, хяналтан дор байдаггүй аливаа эд зүйлсэд ямар нэгэн байдлаар учирсан хохирол, эвдрэл, сүйрэлтэй холбоотой бүх хариуцлагыг хамрах даатгал байна. Энэхүү даатгал нь нэхэмжлэл тус бүрт 1,000,000 ам.доллараас багагүй хэмжээг хамарна.
- (b) 25.2(a)-д заасан даатгал нь хуулиар хориглосноос бусад тохиолдолд дараах нөхцөлтэй байна. Үүнд:
- (i) Гэрээний гүйцэтгэлтэй холбоотой Компани болон түүний Ажилчдын тус тусын эрх, ашгийг даатгасан байх,
 - (ii) Даатгуулагчийг бүрдүүлж буй Тал бүрийг тусдаа этгээд гэж үзэж, Тал бүрт тус тусад нь даатгалын гэрээ гаргасан мэт даатгал нь хэрэгждэг харилцан хариуцлага хүлээх заалтыг тусгах,
 - (iii) Гэрээг хэрэгжүүлэх явцад үүсэн, Компани, түүний ажилчдын эсрэг даатгалын шилжүүлэх шууд ба далд эрхээс татгалзах,
 - (iv) Үйлчилгээ үзүүлэгчийн эзэмшиж буй "Бараа"-ны үнэ цэнээс бага бус үнийн дүнгээр "даатгуулагчийн биечлэн ба хуулиар хянах Бараа"-г хамрах,
 - (v) Аль нэг даатгуулагч даатгалын гэрээний нөхцөлийг зөрчсөн нь даатгалын гэрээгээр нөгөө даатгуулагч талын хамрах хүрээнд сөргөөр нөлөөлөхгүй гэсэн зүйл заалт тусгах.

25.3 Ажилчдын нөхөн олговор ба ажил олгогчийн хариуцлагын даатгал

Үйлчилгээ үзүүлэгчийн аливаа ажилтан эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтан гэж үзэх аливаа хүний амь нас эрсдсэн эсхүл түүнд учирсан бэртэл гэмтэлтэй холбогдон, аливаа тогтоомж, нийтээр мөрдөх хууль болон иргэний хуулийн дагуу гарах бүх Хариуцлагыг хамтрах ажилчдын нөхөн олговор болон ажилчдын хариуцлагын даатгал.

Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох Үйлчилгээг Төслийн талбайд үзүүлэх шаардлагатай бөгөөд ажилчид нь Монгол улсын иргэд бол Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн хүсэлтээр ажилчдын нөхөн олговрын болон ажилчдын хариуцлагын даатгалыг Холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардах даатгал дээр нэмж хэрэгжүүлнэ.

25.4 Үйлчилгээ үзүүлэгчийн үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмж

Хэрэв Гэрээг хэрэгжүүлэхийн тулд Гэрээтэй холбоотойгоор Үйлчилгээ үзүүлэгчээс Сайтад хэрэглэгдэх Ханган нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн байгууламж, тоног төхөөрөмжийг хэрэглэх эсхүл түүнийг ашиглуулах шаардлагатай болвол Үйлчилгээ үзүүлэгчийн үйлдвэрлэлийн байгууламж, тоног төхөөрөмжийн өөрийнх нь үнэлгээгээр уг үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмжинд учирсан бүх хохирол, эвдрэл гэмтлийг хамрах даатгалд даатгуулах эсхүл эзэмшигчийг нь (тухайн үйлдвэрлэлийн байгууламж ба тоног төхөөрөмжийн эзэмшигч нь Компани эсхүл Рио Тинто Группийн гишүүн биш бол) даатгуулахыг шаардана. Хуулиар хориглосноос бусад тохиолдолд энэхүү даатгал нь Компани ба түүний захирлууд, албан тушаалтнууд, ажилчдын даатгалыг шилжүүлэн эсхүл орлуулан тооцох тусгайлсан эрхгүй байна.

25.5 Тээвэрлэлтэнд яваа бараа

Хэрэв Гэрээг хэрэгжүүлэхийн тулд Үйлчилгээ үзүүлэгчээс Дагалдах барааг Сайт руу эсхүл Сайтаас тээвэрлэх шаардлагатай болвол Компанийн бичгээр өгсөн зөвлөмжид өөрөөр заагаагүй бол Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн бараа бүтээгдэхүүний төлбөрийг Компани гүйцэтгэсэн эсэхээс үл хамааран, тээвэрлэлтийн үед бараа бүтээгдэхүүнд гарах аливаа хохирол эвдрэл, гэмтлийг хамарсан даатгалд даатгуулсан байх шаардлагатай. Журмын дагуу уг даатгал нь компанийг гэрээний даатгуулагч тал гэж тэмдэглэнэ.

25.6 Автомашины/тээврийн хэрэгслийн гуравдагч талын хариуцлагын даатгал

- (a) Гэрээг гүйцэтгэх явцад Үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилчид нь автомашин ашиглах, ашиглуулах шаардлагатай бол тухайн автомашиныг ашигласнаас үүдэн гарах аливаа хүнд учирсан осол гэмтэл, амь насны хохирол эсхүл эд хөрөнгөд учрах аливаа хохирол, эвдрэл, сүйрэлтэй холбоотой бүх Хариуцлагыг хамрах хөндлөнгийн хариуцлагын даатгалд Үйлчилгээ үзүүлэгч хамрагдах бөгөөд тухайн автомашин эзэмшигчээс хамрагдахыг шаардах ёстой.
- (b) 25.2(a)-д заасан даатгал нь хуулиар хориглосноос бусад тохиолдолд дараах нөхцөлтэй байна. Үүнд:
- (i) Гэрээний гүйцэтгэлтэй холбоотой Компани болон түүний Ажилчдын тус тусын эрх, ашгийг даатгасан байх,
 - (ii) даатгуулагч Тал бүр тусдаа этгээд гэж тооцогдсон бөгөөд Тал тус бүрт тусдаа даатгалын гэрээ мэт даатгал нь хэрэгждэг харилцан хариуцлага хүлээх заалтыг агуулсан даатгалын гэрээний нэмэлт нөхцөл,

- (iii) Компани, тэдгээрийн ажилчдын эсрэг даатгалын шилжүүлэх шууд ба далд эрхээс татгалзсан даатгалын гэрээний нэмэлт нөхцөл,
- (iv) Аль нэг даатгуулагчийн зөрчил гаргасан байдал нь нөгөө даатгуулагч талын хамрах хүрээнд сөргөөр нөлөөлөхгүй гэсэн Бие даасан байдлын заалтыг хүчин төгөлдөр болгосон даатгалын гэрээний нэмэлт нөхцөл.

25.7 Мэргэжлийн хариуцлагын даатгал

Хэрэв гэрээний гүйцэтгэл мэргэжлийн зөвлөгөө ба үйлчилгээ үзүүлэх үүргийг хамарсан эсхүл үүнтэй холбоотой тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ хэрэгжих хугацаанд болон гэрээг цуцалсны эсхүл Гэрээнд заасан Үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг дуусгавар болсон эсвэл Гэрээ цуцлагдсаны дараа 3-аас доошгүй жилийн туршид Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний дагуу гүйцэтгэсэн мэргэжлийн үйлчилгээ, зөвлөгөөтэй холбоотой хариуцлагыг хамрах, хариуцлагын хэмжээ нь тохиолдол бүрт \$10,000,000-с багагүй хязгаар бүхий мэргэжлийн хариуцлагын даатгал эсхүл аливаа буруутай, хайхрамжгүй ажиллагаатай холбогдсон алдаа, дутагдлын хариуцлагын даатгалаар даатгуулсан байна.

25.8 Даатгалын нөхцлүүд

- (a) Үйлчилгээ үзүүлэгчийн аливаа даатгал нь өөрийгөө даатгах сан эсхүл зөрүүг төлөхтэй холбогдсон бол тэрхүү өөрийгөө даатгах сан эсхүл зөрүүгийн хэмжээг Компанид мэдэгдэх ёстой. Компанийн зүгээс аливаа өөрийгөө даатгах сан эсхүл зөрүүгийн хэмжээг Гэрээний нөхцөл байдлын хувьд зохихгүй гэж үзвэл Үйлчилгээ үзүүлэгчээс тухайн хэмжээг багасгахыг шаардах эрхтэй.
- (b) Үйлчилгээ үзүүлэгч даатгалаа нь А.М. Best Company-аас гаргасан үнэлгээний "А"-с доошгүй түвшний нэр хүнд бүхий даатгагчаар, эрсдлийн хянуур менежментийн арга барилд нийцсэн нөхцлөөр хийлгэнэ.
- (c) Энэхүү 25-д заасан аливаа заалт нь Үйлчилгээ үзүүлэгчийн энэхүү аливаа хариуцлагыг хязгаарлахгүй.
- (d) Үйлчилгээг гүйцэтгэхээс өмнө болон гэрээг шинэчилж, нэмэлт өөрчлөлт оруулах бүрт Үйлчилгээ үзүүлэгч болон түүний туслан гүйцэтгэгч нар нь Гэрээний дагуу даатгуулагдсан болохыг гэрчлэх даатгалын гэрчилгээ эсхүл Компаниас зохих ёсоор шаардсан бусад нотлох баримтыг Компанид ирүүлнэ.
- (e) Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийгөө болон туслан гүйцэтгэгч нараа энэхүү Гэрээний дагуу шаардагдах даатгалд хамруулж чадаагүй тохиолдолд Компанийн зүгээс дараах нэг болон түүнээс дээш арга хэмжээг авна. Үүнд:
 - (i) Тухайн даатгалд хамруулж, зардлыг нь Үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой мөнгөн дүнгээс суутган авах
 - (ii) Үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилчдыг Төслийн талбайд эсхүл аль нэг хэсэг нь нэвтрүүлэхээс татгалзах,
 - (iii) Даатгуулаагүй байдлыг Гэрээний зөрчил гэж хүлээн авах.
- (f) Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн төлөөлөгчөөс бичгээр зөвшөөрөл авах хүртэл Үйлчилгээ үзүүлэгчийн бүх даатгалыг Компани болон түүний ажилчдад хохиролтой байдлаар өөрчлөх, цуцлах эсхүл хүчингүй байлгаж болохгүй.

25.9 Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний дагуух мэдэгдэл

Хэрэв энэхүү 25-р зүйлийн шаардсанаар Үйлчилгээ үзүүлэгч аливаа даатгалын гэрээний дагуу Компанитай холбоотой гомдол заргыг нэмэгдүүлж болох ямар нэг үйл явдлын талаар Үйлчилгээ үзүүлэгч нь мэдэж байгаа бол, энэ талаар Үйлчилгээ үзүүлэгч Компанид мэдэгдэх ёстой бөгөөд тэрхүү гомдол саналтай холбоотой дараагийн арга хэмжээний талаар Компани бүрэн мэдэж байх явдлыг хангаж ажиллана.

25.10 Туслан гүйцэтгэгчдийн даатгал

Үйлчилгээ үзүүлэгч нь Туслан гүйцэтгэгчид Үйлчилгээ үзүүлэгчийн даатгуулахыг шаардсан Үйлчилгээ үзүүлэгчийн даатгалуудтай төстэй даатгалуудад хамрагдсаар байх, тэдгээр даатгалын үр дүн, ашиг тусыг авах явдлыг хангаж ажиллана.

25.11 Даатгалын нөхөн олговрын нэхэмжлэх ба нөхөн олговрын зөрүүг төлөх

- (a) Үйлчилгээ үзүүлэгчийн хамрагдсан даатгалтай холбоотой илүүдэл эсхүл хасагдах зөрүүгийн төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгч хариуцах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгчийн төлсөн аливаа илүүдэл эсхүл хасагдах зөрүүг Компаниас гаргуулах эрх Үйлчилгээ үзүүлэгчид байхгүй.
- (b) Компанийн зүгээс Үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилчид тухайн хохирол, эвдрэлд хариуцлага хүлээх ёстой гэж үзэн холбогдох бодлогын дагуу нэхэмжлэл гаргасан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн хамрагдсан даатгалтай холбоотой илүүдэл эсхүл хасагдах зөрүүгийн төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

26. Нөхөн төлбөр

26.1 Хүлээн зөвшөөрөх

Үйлчилгээ үзүүлэгч нь төслийн талбайд нэвтрэх бол эрсдэлээ өөрөө хүлээж ийнхүү нэвтрэхээ Үйлчилгээ үзүүлэгчхүлээн зөвшөөрнө. Үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжилтэн Төслийн талбайд нэвтрэх бол эд эрсдэлээ өөрсдөө хүлээж ийнхүү нэвтэгч буйгаа хүлээн зөвшөөрсөн байгааг Үйлчилгээ үзүүлэгч бататгана.

26.2 Нөхөн төлбөр

26.3-р заалтын дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь дараах тохиолдлын аль нэгнээс үүдэн Нөхөн төлбөр авах талд учирсан, тулгарсан тухайн талын хүлээсэн бүх Хариуцлагаас хамгаалж, хохиролгүй болгоно. Үүнд:

- (a) Үйлчилгээ үзүүлэгч болон түүний ажилчид нь гэрээний дагуу ба/эсхүл Худалдан авах захиалгын дагуу хүлээсэн Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг (мөн аливаа баталгаа) зөрчсөн,
- (b) Гэрээг эсхүл Худалдан авах захиалгыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Үйлчилгээ үзүүлэгч эсхүл түүний ажилтны гаргасан хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэл болон Санаатай зохисгүй үйлдэл,
- (c) Орлогын албан татвар, ажилчдын нөхөн олговор, улирлын амралт, урт хугацааны цэргийн албан хаах чөлөө, тэтгэвэр болон холбогдох урамшуулал, зохих үйлдвэрчний шүүхийг томилох, хүлээн зөвшөөрөхтэй хамаарах холбогдох хууль тогтоомжтой холбогдуулан Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтаны зүгээс Компани эсхүл Рио Тинто Группын гишүүний эсрэг гаргасан аливаа нэхэмжлэл.

26.3 Онцгой тохиолдол

Үйлчилгээ үзүүлэгч нь компанийн аливаа буруутай, алдаатай болон санаатай зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан эсвэл түүний нөлөөгөөр үүссэн хохирлын хариуцлагыг 26.2 заасны дагуу хүлээх үүрэггүй.

26.4 Нөхөн төлбөрийн эрх эдлэхээс өмнө зардал гаргахгүй байх

Компани, Рио Тинтогийн гишүүн болон тэдгээрийн Ажилчид нь Гэрээний дагуу олгосон нөхөн төлбөрийн эрхээ эдлэхээс өмнө зардал гаргах эсхүл төлбөр төлөх шаардлагагүй.

27. Зөрчил гараагүй үед Гэрээ цуцлах

27.1 Гэрээ цуцлах тухай мэдэгдэл

Компани нь 30-аас доошгүй хоногийн өмнө үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэл хүргүүлснээр Гэрээг эсхүл түүний аль нэг хэсгийг цуцалж болно. (*Гэрээ цуцлах мэдэгдэл*)

27.2 Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авсанаар хүлээх үүрэг

Гэрээ цуцлах мэдэгдлийг хүлээн авсанаар үйлчилгээ үзүүлэгч нь:

- (a) Бүх ажилтны аюулгүй байдал болон бүх бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтыг хангах боломжит бүх арга хэмжээг нэн даруй, өөрийн зардлаар авах;
- (b) Гэрээ цуцласны улмаас үүссэн аливаа өр төлбөрийг багасгах бүх боломжит бүх арга хэмжээг нэн даруй авах;
- (c) Гэрээг цуцлахтай холбоотойгоор Компаниас үндэслэлтэйгээр шаардсан бусад арга хэмжээг авах ёстой.

27.3 Гэрээ цуцлах үед хүлээх үүрэг

Гэрээ цуцлах мэдэгдэлд тусгайлан заасан өдөр Үйлчилгээ үзүүлэгч нь дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:

- (a) Гэрээ цуцлах мэдэгдлийн дагуу, түүнд заасан хэмжээгээр Үйлчилгээний гүйцэтгэлийг яаралтай зогсоох;
- (b) Үйлчилгээний гүйцэтгэлийг зогсоох хүртэлх өдрийн байдлаар (Гэрээ цуцлах мэдэгдэл хүлээн авсан өдрийг оролцуулан) Компаниас шаардсан маягтын дагуу дэлгэрэнгүй тайланг бэлтгэн Компанид өгөх;
- (c) Гэрээ хэрэгжих хугацааны туршид Компаниас Үйлчилгээ үзүүлэгчид гарган өгсөн аливаа зүйлийг буцаан өгөх;
- (d) Үйлчилгээ үзүүлэгчийн Гэрээг хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн аливаа тоног төхөөрөмжийг түүний элдэгдэл тооцсон өртөг эсхүл талуудын харилцан тохиролцсон үнэлгээгээр Компанид худалдах санал тавих ба уг саналаас түрүүлж татгалзах эрхийг Компани хадгална;
- (e) Гэрээ цуцлахтай холбоотойгоор Компанийн үндэслэл бүхий шаардсан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр болно.

27.4 Үйлчилгээ үзүүлэгчид нөхөн төлбөр олгох

- (a) Энэхүү 27-р заалтын дагуу Компани гэрээ цуцлах тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэхэд гарсан цалин хөлснөөс бусад дараахь зардлыг дан ганц Гэрээний улмаас учирсан буюу учирч болох бөгөөд түүнийг өөрөөр нөхөн төлөх эсхүл бууруулах боломжгүй тохиолдолд Компаниас нөхөн төлүүлэх эрхтэй. Үүнд:
- (i) сайтаас Үйлчилгээ үзүүлэгчийн үйлдвэрлэлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал;
 - (ii) Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтныг ажилд авсан газар руу нь буцаан тээвэрлэхтэй холбоотой зардал зэрэг багтана.
- (b) (б)27.4(а)-д заасан мөнгөн дүнгийн хэмжээ нь зөвхөн 27-р заалтын дагуу Компани гэрээ цуцалсан тохиолдолд Компаниас Үйлчилгээ үзүүлэгчид төлөх дүнг буюу нөхөн төлбөрийн хэмжээг илэрхийлнэ.

28. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчих

28.1 Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл

Хэрэв Үйлчилгээ үзүүлэгч Гэрээний аливаа нөхцөлийг зөрчсөн тохиолдолд Компани 26.2-т тодорхойлсон мэдээлэл бүхий Мэдэгдлийг (*Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл*) Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

28.2 Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд тавигдах шаардлага

Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэл нь:

- (a) Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлснээс хойш 30-аас доошгүй хоногийн дотор байх тусгайлан заасан хугацаанд аливаа зөрчлийг засч залруулахыг шаардах эсхүл тухайн зөрчил нь засагдах боломжгүй бол энэ талаар заах;
- (b) Хэрэв уг зөрчлийг Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдэлд заасан хугацааны дотор засч залруулаагүй эсхүл тухайн зөрчил нь засагдах боломжгүй тохиолдолд Компани дараахь арга хэмжээний аль нэгийг эсхүл хэд хэдийг хэрэгжүүлж болохыг заасан буюу дор дурдсан мэдээлэл бүхий дараагийн Мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ. Үүнд:
- (i) Үйлчилгээ үзүүлэгч зөрчлийг засч арилгах хүртэл Гэрээний төлбөрийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь зогсоохын аль нь болохыг дурдах;
 - (ii) Зөрчлийг залруулахад зайлшгүй шаардлагатай гэж Компанийн үзсэн тухайн арга хэмжээг авах (Компаниас авах тухайн арга хэмжээний зардал нь Үйлчилгээ үзүүлэгчээс Компанид нөхөн төлөх нөхцөлтөйгөөр үүссэн Үйлчилгээ үзүүлэгчийн Компанид өгөх өглөг болно.);
 - (iii) Гэрээг эсхүл түүний аль нэг хэсгийг тусгайлан заасан өдрөөр цуцлах (*Цуцлах өдөр*) зэргийг тусгана.

28.3 Гэрээг цуцлах үед хүлээх үүрэг

Хэрэв Компани 28.2(b)(iii)-д зааснаар Мэдэгдэл өгсөн бол тусгайлан заасан өдрөөр Гэрээ цуцлагдах бөгөөд Үйлчилгээ үзүүлэгч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- (a) Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний үүргээ зөрчсөн тухай мэдэгдлийн дагуу, түүнд заасан хэмжээгээр Үйлчилгээний гүйцэтгэлийг яаралтай зогсоох;
- (b) Бүх ажилтны аюулгүй байдал болон бүх бараа бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалтыг хангах боломжит бүх арга хэмжээг нэн даруй, өөрийн зардлаар авах;
- (c) Гэрээ цуцалсны улмаас үүссэн аливаа өр төлбөрийг багасгах бүх боломжит бүх арга хэмжээг нэн даруй авах;
- (d) Үйлчилгээ үзүүлэгчийн Гэрээ хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэсэн аливаа тоног төхөөрөмжийг түүний элдэгдэл тооцсон өртөг эсхүл талуудын харилцан тохиролцсон үнэлгээгээр Компанид худалдах санал тавих ба уг саналаас түрүүлж татгалзах эрхийг Компани хадгална;
- (e) Гэрээ цуцлахтай холбоотойгоор Компанийн үндэслэл бүхий шаардсан бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

28.4 Хохиролгүй болгох

Үйлчилгээ үзүүлэгчийн гэрээний үүргээ зөрчсөн тухай аливаа мэдэгдлийн нөхцөлөөс үл хамааран, энэхүү 28-р заалтын дагуу Компанийн зүгээс авч хэрэгжүүлсэн ямар ч арга хэмжээ нь холбогдох зөрчлийн улмаас Гэрээний дагуу Компанийн эдлэж болох аливаа эрх эсхүл хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг хязгаарлахгүй.

29. Маргаан шийдвэрлэх

29.1 Маргаан

Компани ба Үйлчилгээ үзүүлэгчийн хооронд Гэрээний улмаас үүссэн аливаа маргаан, асуулт болон ойлголцлын зөрүү гарсан (**Маргаан**) тохиолдолд нэг тал нь нөгөө талдаа 29-р заалтын дагуу маргаан болон түүнийг шийдвэрлэхийг шаардсан тухай тодорхой заасан мэдэгдлийг (**Маргааны тухай мэдэгдэл**) хүргүүлнэ.

29.2 Талуудын маргаан шийдвэрлэх төлөөлөгчид

- (a) Хэрэв маргааны тухай мэдэгдлийг нөгөө Талд хүргүүлсэнээс хойш 7 хоногийн хугацаанд маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Тал тус бүр өөрсдийн ахлах удирдлагаас нэг төлөөлөгчийг (Маргааны төлөөлөгч) маргаан шийдвэрлүүлэхээр нэр дэвшүүлнэ.
- (b) Хэрэв 30 хоногийн хугацаанд (эсхүл талуудын харилцан тохиролцсон тухайн хугацаанд) Маргааныг шийдвэрлэх хамтарсан шийдвэр гараагүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч болон Компани нь тухайн маргаантай асуудлыг UNCITRAL (НҮБ-ын олон улсын худалдааны хуулийн комисс)-ын Арбитрийн дүрмийн хүрээнд Сингапур улс дахь Олон Улсын Арбитрын Төвд шилжүүлэхээр харилцан тохиролцов. Арбитрын ажиллагаанд хэрэглэх хэл нь Англи хэл байх ба явагдах газар нь Сингапур улс байна. Арбитрын ажиллагааг талуудын харилцан зөвшөөрсөн хөндлөнгийн нэг (1) арбитрч эсхүл хэрэв талуудын нэг тал нь нөгөө талдаа арбитраар маргаан шийдвэрлүүлэх тухай эхний шаардлага тавьсанаас хойш гуч (30) хоногийн дотор нэг арбитрчийг сонгох тухай харилцан зөвшилцөж чадаагүй бол гурван (3) арбитрчийн бүрэлдэхүүнтэй баг (талууд тус бүр нэг арбитрчийг томилох ба томилогдсон арбитрч нар хамтдаа гуравдахь арбитрчийг сонгоно) удирдан явуулна. Арбитрч нар, Талууд, Маргааны төлөөлөгчид болон оролцогч нар нь аливаа арбитрын ажиллагаа, агуулга, үр дүнгийн нууцлалыг зохих ёсоор эсхүл холбогдох хуульд өөрөөр шаардсаны дагуу хангана.
- (c) Арбитрч нар нь энэхүү Гэрээний нөхцлийг заавал биелүүлж, хатуу мөрдүүлэх бөгөөд Гэрээний нөхцлийг хязгаарлах, дэлгэрэнгүй болгох болон түүнд засвар өөрчлөлт оруулахгүй. Арбитрч нар нь томилогдсоноосоо хойш 6 сарын дотор арбитрын ажиллагааг дуусгаж, зохих шийдвэрээ гаргахыг эрмэлзэнэ. Талууд тус бүр энэхүү заавал биелүүлэх арбитрын ажиллагааны зардлаа гаргана. Арбитрын шийдвэр нь эцсийн байдлаар гарч, Талууд бүгд түүнийг заавал даган биелүүлэх бөгөөд шийдвэрийн дагуу гарсан тогтоолыг холбогдох харьяаллын шүүхэд өгч болно

29.3 Маргаан үүссэн үе дэх гэрээний үүргийн гүйцэтгэл

Аливаа маргаан үүссэн үед Талууд өөрөөр тохиролцоноос бусад тохиолдолд тэдний Маргаан дахь байр суурьнаас үл хамааран Гэрээний дагуух үүргийн гүйцэтгэлийг үргэлжлүүлэх ёстой.

29.4 Яаралтай үед түр зуурын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Энэхүү 29-р заалт нь Гэрээний дагуу шаардагдаж болох, яаралтай үед авч хэрэгжүүлэх аливаа түр зуурын арга хэмжээг хориглохгүй.

30. Нууцлал

30.1 Нууцлалыг хангах үүрэг

Компаниас энэ тухай урьдчилан бичгээр зөвшөөрөл (Компани өөрийн үзэмжээр тухайн мэдээллийг бусдад задруулахыг хориглосон эсхүл авч ашиглахыг зөвшөөрсөн тухай) авсанаас бусад тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч дараах үйл ажиллагааг явуулах ба зөвшөөрнө. Үүнд:

- (a) бүх нууц мэдээллийн нууцыг чанд хадгалж задруулахгүй байх, нууц мэдээлэл авч ашиглах зөвшөөрлийг Үйлчилгээг үзүүлэхтэй холбогдуулан Нууц мэдээлэлтэй харьцах шаардлага бүхий этгээдийн аливаа ажилтнаас бусад этгээдэд өгөхгүй.
- (b) Үйлчилгээний гүйцэтгэлд зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд шаардагдах хэр хэмжээнээс хэтрүүлэлгүйгээр (хуулбарлах, дахин үйлдэх, тараах эсхүл шууд болон шууд бусаар нууц мэдээллээс ашиглах зэргийг оролцуулан) Нууц мэдээллийг авч ашиглахгүй байх зэрэг болно.

30.2 Онцгой тохиолдол

30.1 дэх заалт дараахь тохиолдолд хамаарахгүй. Үүнд:

- (a) Үйлчилгээ үзүүлэгчид нууцлалын талаар оногдуулсан аливаа нэг үүрэг эсхүл энэхүү 30-д заасныг зөрчсөнөөс бусад тохиолдолд нэгэнтээ нийтийн хүртээл болсон мэдээлэл
- (b) аливаа хууль тогтоомж, хуулийн хүчин чадал бүхий шүүхийн тогтоол, Засгийн газрын эрх бүхий байгууллагаас эсхүл нэр хүнд бүхий хөрөнгийн биржээс гаргасан аливаа шийдвэрийг биелүүлэх зорилгоор Үйлчилгээ үзүүлэгчээс тухайн мэдээллийн дэлгэрэнгүй танилцуулга бүхий мэдэгдлийг Компанид урьдчилан өгсөн зэрэг болно.

30.3 Зөвшөөрлийг зөрчих

30.1-р заалтын дагуу олгосон зөвшөөрөлд заасан аливаа нөхцлийг зөрчсөнөөр Гэрээний зөрчил гэж үзнэ.

30.4 Үйлчилгээ үзүүлэгч хүлээн зөвшөөрөх

Үйлчилгээ үзүүлэгч энэхүү 30-р заалт нь Компанийн төдийгүй аливаа аливаа нууц мэдээллийг авах сонирхол бүхий Рио Тинто Группийн аль ч гишүүний ашиг тусын тулд байхыг хүлээн зөвшөөрнө.

30.5 Нөхөн төлбөр

26-р заалтаар үл хязгаарлагдан, Үйлчилгээ үзүүлэгч, түүний аливаа ажилтан энэхүү 30-р заалтыг зөрчсөний улмаас Компани болон Рио Тинто Группийн гишүүн бүрт учруулсан аливаа хохирол, хүлээсэн алдагдлыг Үйлчилгээ үзүүлэгч нөхөн төлж, тэдгээрийг хохиролгүй болгох ёстой.

30.6 Нэмэлт хариуцлага

Энэхүү энэхүү 30-р заалтад тусгасан үүрэг нь нийтийн эрх зүйн болон аливаа хууль журмын хүрээнд эсхүл худалдааны болон мэргэжлийн хэрэгцээний нууц мэдээлэлтэй холбоотойгоор Үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх үүрэг дээр нэмж хэрэгжих ба тухайн үүргийг бууруулж зохицуулахгүй.

30.7 Нууц мэдээллийг буцаах

Хэрэв Гэрээ дуусгавар болохоос өмнө болон хойно, эсхүл уг хугацаанаас өмнө гэрээ цуцлагдсан эсэхийг харгалзахгүйгээр, Компани хүсэлт гаргасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн болон Ажилчдынхаа хадгалалт хамгаалалт, эзэмшил эсхүл хяналтанд байдаг бүх мэдээллийг Компанид нэн даруй буцаах ёстой.

31. Нийтэд зарлан мэдээлэх

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмаар шаардсанаас эсхүл Гэрээнд өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь Компанийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр Гэрээний агуулгаас өөрөөр олон нийтэд аливаа мэдээлэл хийж болохгүй. Үүнтэй холбоотойгоор Компанийн бичгээр үйлдсэн зөвшөөрөлгүйгээр эсхүл тухайн зөвшөөрлийг Компаниас олгосон байх шаардлагатай тохиолдолд Гэрээний талаар хэвлэл мэдээллээр цацах эсхүл олон нийтэд хүргэх аливаа мэдээлэлийн үг хэллэг болон нийтлэлийн агуулга дээр Компаниас бичгээр зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

32. Оюуны өмчийн эрх

32.1 Үйлчилгээ үзүүлэгчийн оюуны өмч

Үйлчилгээ үзүүлэгч нь Гэрээний дагуу Үйлчилгээг гүйцэтгэх, Бараа, холбогдох үйлчилгээ хүргэх явцад ашиглаж, бий болгосон Үйлчилгээ үзүүлэгчийн оюуны өмчийг эзэмшигч хэвээр үлдэхийг Компани хүлээн зөвшөөрнө. Рио Тинтогийн үйл ажиллагаатай холбогдуулан Бараа, Холбогдох үйлчилгээний үр шимийг Компанид хүртээх зорилгоор үйлчилгээ үзүүлэгчийн бүх оюуны өмчийн эрхийг тухайн зорилгоор компани онцгой бус эрхтэй, шилжүүлэх боломжтой, үнэ төлбөргүй, эргэлт буцалтгүй, хугацаагүй нөхцөлөөр ашиглах тусгай зөвшөөрөл олгоно.

32.2 Гуравдагч талын Оюуны Өмчийн Эрх

Үйлчилгээ үзүүлэгч нь Үйлчилгээний биелэлтэд аливаа гуравдагч талын Оюуны Өмчийн Эрхийг ашиглах болон ашиглахыг санал болгох эсвэл Компани нь үйлчилгээний ашиглалт болон хэрэглээнд аливаа гуравдагч талын Оюуны өмчийг ашиглах эсвэл ашиглахыг санал болгох нь дор дурдсан байдлаар баталгаа гаргана:

- (a) Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн гуравдагч талын шаардлагатай бүх Оюуны өмчийг эрхийг ашиглах лиценз, зөвшөөрөл авах болон эрхийг шилжүүлэн авахдаа Компаниас ямар нэг зардал гаргахгүй.
- (b) Үйлчилгээ үзүүлэгч нь 32.2(a) заалтад тусгасан аливаа тусгай зөвшөөрөл болон эрхийн шилжүүлэгтэй холбоотой заалтыг зөрчихгүй.

32.3 Нөхөн төлбөр

- (a) 26-р заалтаар үл хязгаарлагдан Үйлчилгээ үзүүлэгч нь дараахь шалтгааны улмаас үүсэх аливаа Гуравдагч талын Оюуны өмчийн бодит болон сэжиг бүхий зөрчлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх ба Компанийн нөхөн төлбөр авах эрхийг хадгална:
 - (i) Үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэсэн үйлчилгээ
 - (ii) Үйлчилгээ үзүүлэгчийн ашигласан болон нийлүүлсэн бусад аливаа үйлдвэрийн газрын үйл ажиллагааны гүйцэтгэл, тоног төхөөрөмж, машин, сэлбэг хэрэгсэл, хэрэглэл, ажил, материал
 - (iii) Компанийн хэрэглэсэн болон ашигласан үйлчилгээ.
- (b) Үйлчилгээ үзүүлэгч нь 32.3(a)-д зааснаар Компанид нөхөн төлбөрт хамрагдах аливаа зүйлстэй холбоотойгоор аюул учирсныг мэдсэн даруйдаа Компанид мэдэгдэнэ.

- (с) Компани нь 32.3(b)-д заасантай холбоотой шаардлагаас үүсч болох аливаа нэхэмжлэл болон тухайн нэхэмжлэлийг шийдвэрлэх бүх хэлэлцээг зохион байгуулахыг үйлчилгээ үзүүлэгчээс хүсч болно. Гэвч Үйлчилгээ үзүүлэгч нь компанийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа компанийн эсрэг аливаа шүүхийн шийдвэр, тушаал, тогтоолын өмнө ямарваа шийдвэр болон зөвшөөрлийг үйлдэх ёсгүй

32.4 Оюуны Өмчийн Эрхийн Худалдан авах ажиллагаа

Хэрэв Компани нь оюуны Өмчийн Эрхийн зөрчилтэй холбоотой аливаа нэхэмжлэлийн улмаас Үйлчилгээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хэрэглэхээс саатуулагдсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь бүх үйлчилгээ болон түүний хэсгийг түүний зориулалтын дагуу хэрэглэх эрхийг компанид худалдан авч өгөх боломжит бүх арга хэмжээг (өөрийн зардлаар) авах үүрэгтэй.

32.5 Оюуны өмчийн эрх худалдан авах боломжгүй үеийн журам

Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь 32.4-р заалтад тусгагдсан эрхийг боломжит хугацаанд (Компанийн төлөөлөгч өөрөөр зөвшөөрөөгүй бол 60 хоногийн хугацаанаас хэтрүүлэхгүй) худалдан авах боломжгүй бол тэр талаар компанийн төлөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй ба Компанийн төлөөлөгч дараахь журмаар Үйлчилгээ үзүүлэгчийг (Үйлчилгээ үзүүлэгчийн зардлаар) чиглүүлж болно:

- (a) Оюуны өмчийн эрхийн зөрчлөөс зайлсхийхээр үйлчилгээ эсхүл үйлчилгээний холбогдох хэсгийг өөрчлөх
- (b) Үйлчилгээ эсхүл үйлчилгээний зөрчилд нөлөөлөх болон холбогдох хэсгийг Оюуны өмчийн эрхэд зөрчилдөхгүй ажил ба бараа бүтээгдэхүүнээр орлуулах, дахин гүйцэтгэх.
- (c) Үйлчилгээний гүйцэтгэлийг зогсоох мөн компанийн нөхөн төлбөр болон компаниас үйлчилгээ үзүүлэгчид төлөгдсөн мөнгийг буцаан төлж зогсоосон үйлчилгээтэй холбоотойгоор компанид үүсч болох аливаа зардал болон бусад төлбөрийг төлнө.

33. Мэдэгдэл

33.1 Мэдэгдлийн хэлбэр

Гэрээний дагуу хийгдэх эсхүл хүргүүлэх аливаа мэдэгдэл, шаардлага, зөвшөөрөл болон бусад харилцаа холбоо (*Мэдэгдэл*) нь:

- (a) Бичгээр хийгдсэн;
- (b) Компаниас гаргаж буй тохиолдолд Компанийн төлөөлөгч болон компанийн Хангамжийн хэлтсийн менежер гарын үсэг зурж баталгаажуулсан эсхүл Компанийн төлөөлөгч албан ёсоор баталсан;
- (c) Мэдэгдэл хаяглагдсан талын Гэрээнд дурдсан хаягаар эсхүл тухайн тал нь нөгөө талд мэдэгдсэн өөр бусад хаягаар гарт нь эсхүл факсаар, урьдчилсан төлбөрт шуудангаар хүргүүлж болно.

33.2 Мэдэгдлийг хүлээн авсан гэж үзэх

Мэдэгдлийг дараахь тохиолдолд албан ёсоор хүргэгдсэн гэж үзнэ. Үүнд:

- (a) гарт нь хүргүүлэхээр илгээхэд мэдэгдэл хүргэгдсэн бол;
- (b) Шуудангаар илгээх тохиолдолд, илгээсэн өдрөөс хойш ажлын 2 хоног (нэг улс доторх хаяг уруу илгээсэн бол) эсхүл илгээсэн өдрөөс хойш ажлын 7 хоног (өөр улс дахь хаяг уруу илгээсэн бол);
- (c) Факсаар илгээх тохиолдолд, Илгээгчийн илгээх машины хяналтын тайлан дээр харагдаж буй илгээсэн хуудасны тоо, хүлээн авах факсын машины дугаар, хүлээн авагчийн нэр болон дугаар, түүнчлэн дамжуулалт алдаагүй хийгдсэнийг гэрчлэх мэдээллийг үндэслэх
- боловч хэрэв Мэдэгдэл хүргэгдэх эсхүл үйлдэгдэх өдөр ажлын өдөр биш бол эсхүл Мэдэгдэл 16 цагаас (орон нутгийн цагаар) хойш илгээсэн тохиолдолд Мэдэгдлийг дараагийн ажлын өдрийн ажил эхлэхэд албан ёсоор хүргэгдсэн гэж үзнэ.

34. Зардал

34.1 Талууд өөрсдийн зардлыг хариуцах

Талууд тус бүр дараахь тохиолдлын улмаас үүссэн өөрсдийн зардлыг хариуцна. Үүнд:

- (a) Гэрээний хэлэлцээ хийх, бэлтгэл ажил болон хэрэгжүүлэх;
- (b) Гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол Гэрээний хэрэгжилтийн үед хянагдсан бусад гүйлгээтэй холбогдох зардлууд байна.

34.2 Тэмдэгтийн хураамж

Аливаа холбогдох хууль тогтоомжийн дагуу эсхүл Гэрээ, аливаа худалдан авалтын захиалга болон бусад баримт бичгүүдтэй холбоотойгоор төлөгдөх шаардлагатай байж болох бүхий л тэмдэгтийн хураамжийг Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

35. Үйлчилгээ үзүүлэгчийн статус

35.1 Хараат бус гүйцэтгэгч

Гэрээ хэрэгжих бүхий л хугацааны туршид буюу Үйлчилгээг үзүүлэх үед Үйлчилгээ үзүүлэгч нь хараат бус гүйцэтгэгч байх бөгөөд Компанийн ажилтан, агент буюу харьяа байгууллага нь байх тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч, түүний ажилтан нь Компанийн аливаа ажилтны тогтмол хангагддаг ямар нэг урамшуулал, нэмэгдэл зэргийг тэдгээрийн нэгэн адил статус бүхий давуу эрхээр хүлээн авах эрхгүй болно.

35.2 Түншлэл, хамтарсан нийлүүлэгч

Үйлчилгээ үзүүлэгч нь нэгээс олон этгээдээс бүрдэж байгаа тохиолдолд тэдгээр нь Гэрээг хэрэгжүүлэхэд хамтын болон тус тусын хариуцлага хүлээнэ гэдгээ албан ёсоор тодорхойлж, Гэрээний дагуу учирч болох аливаа алдагдал, гарз хохирол болон Гэрээний нөхцөлийн дагуу Компанид төлөх шаардлага үүсч болох аливаа дүнг хамтран болон тус тусдаа хариуцахыг хүлээн зөвшөөрнө.

36. Эрх, үүргээ шилжүүлэх болон Туслан гүйцэтгүүлэх

36.1 Компани зөвшөөрөл олгох

Үйлчилгээ үзүүлэгч Компанийн төлөөлөгчөөс бичгээр үйлдсэн зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр Гэрээний бүхэсхүлаль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэхийг хориглох ба уг зөвшөөрөлд Компанийн төлөөлөгчөөрийн шаардлагатай гэж үзсэн холбогдох нөхцөл, болзол болон санал болгож буй Туслан гүйцэтгэгчийг Гэрээний аль нэг бүх нөхцөл заалтыг дагаж мөрдөхийг шаардсан тухай дурдсан байна.

36.2 Туслан гүйцэтгүүлэх эсвэл эрх үүрэг шилжүүлэхэд хүчинтэй байх үүрэг

Үйлчилгээ үзүүлэгч нь зөвшөөрөл авсан хэдий боловч аливаа нэг туслан гүйцэтгүүлэх ажиллагаа нь Үйлчилгээ үзүүлэгчийг Гэрээний дагуу түүний гүйцэтгэх аливаа үүргийн биелэлтээс ямар нэгэн байдлаар чөлөөлөхгүй гэдгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулна.

36.3 Туслан гүйцэтгэгчийн статус

Компани болон Үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллаж байгаа Туслан гүйцэтгэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн агент буюу ажилтан гэж тооцогдоно. Гэрээг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Туслан гүйцэтгэгч, түүний аливаа ажилтны үйлдэл, эс үйлдэхүйг Үйлчилгээ үзүүлэгчийн үйлдэл, эс үйлдэхүй гэж үзнэ.

37. Хувийн нууцлал ба мэдээлэл хамгаалал

37.1 Хувийн мэдээллийн хамгаалах

Тал бүр Гэрээний дагуу хүлээж авсан болон нийтэд хүртээл болсон аливаа хувийн мэдээлэлтэй холбоотой бүх хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрнө.

37.2 Баталгаа

Тал бүр Гэрээний дагуу нэг Талын гаргаж өгсөн Хувийн мэдээллийг авахдаа Хувийн нууцлалын талаарх хууль тогтоомжийг мөрдөж ажилласан баталгааг нөгөө талдаа гаргаж өгнө.

37.3 Мэдээллийн хамгаалалт

Холбогдох хуулийн дагуу хүлээсэн үүргээс нь гадна Үйлчилгээ үзүүлэгч нь дор дурдсан ажиллгааг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- (a) Компанийн хувийн мэдээллийг зөвхөн Гэрээний зорилгоор ашиглах;
- (b) Компанийн хувийн мэдээллийг мэдээллийн нээлттэй байдлыг хуулиар шаардаагүй бол, компанийн бичгээр үйлдсэн зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр бусад этгээдэд задруулахгүй;
- (c) Компанийн хувийн мэдээллийн нээлттэй байдал хуулиар шаардагдаж болох талаар Компанид нэн даруй мэдэгдэх;
- (d) Компанийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй болон хууль бусаар ашиглахаас сэргийлэх зохих техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг боловсруулж, мөрдөх
- (e) Компанийн хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, түүнийг алдах, устгах, буруугаар ашиглах, засч өөрчлөх, задруулах болон гэмтээхээс сэргийлэх зохих техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг боловсруулж, мөрдөх;

- (f) Компанийн хувийн мэдээллийг ашиглах ажиллагаа нь хуулийн дагуу, шударга байдлаар ашиглах байгаа гэдгийг баталгаажуулахын тулд бүхий л шаардлагатай арга хэмжээг авсан байх ба түүнчлэн Компани нь өөрийн хувийн мэдээллийг хэрхэн хамгаалдаг хэлбэрээр нэгэн адил ажиллах тухай шаардлагыг Үйлчилгээ үзүүлэгчид тавьж болно.

37.4 Хувь хүний гаргасан гомдол

- (a) Хэрэв Үйлчилгээ үзүүлэгчийг (эсхүл түүний аливаа ажилтныг) Гэрээ гүйцэтгэхдээ тухайн хүний Хувийн мэдээллийг буруугаар ашигласан гэсэн үндэслэл бүхий гомдлыг хувь хүн Компанид гаргасан бол, Компани нь Үйлчилгээ үзүүлэгчид гомдлын талаар мэдээллийг дэлгэрэнгүй дурдсан мэдэгдлийг нэн даруй хүргүүлж, цаашид мэдээллийг буруугаар ашиглах эрсдлийг бууруулна.
- (b) Хэрэв хувь хүн Үйлчилгээ үзүүлэгчид Үйлчилгээ үзүүлэгч (эвсэл түүний ажилтан) хувь хүний өөрийнх нь хувийн мэдээллийг буруугаар ашиглаж байгаа талаар гомдол гаргасан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь дор дурьдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
- (i) тухайн гомдлын талаар Компанид нэн даруй мэдээлэх;
- (ii) хувь хүн зөвшөөрсөн тохиолдолд тухайн гомдол гарсан хувийн мэдээллээр компанийг хангах;

37.5 Үйлчилгээ үзүүлэгчийн нөхөн төлбөр

26-р заалтаар үл хязгаарлагдан Үйлчилгээ үзүүлэгч Холбогдох хууль тогтоомж болон энэхүү 37-р заалтын дагуу хүлээсэн үүргээ зөрчсөнтэй холбогдуулан Компанийн эсрэг гаргасан бүх Хариуцлагаас Компанийг хамгаалж, хохиролгүй болгоно.

38. Эрхээсээ татгалзах

Тал бүр аливаа эрх, эрх мэдэл эсвэл эрх зүйн арга хэрэгслийг хэрэгжүүлээгүй эсхүл хожимдож хэрэгжүүлсэн нь эрхээсээ татгалзсан тооцогдохгүй. Аливаа эрх, эрх мэдэл, эрх зүйн арга хэрэгслээ дангаар нь эсвэл хэсэгчлэн хэрэгжүүлэх нь бусад эсвэл цаашид эрх, эрх мэдэл, эрх зүйн арга хэрэгслээ хэрэгжүүлэхэд саад учруулахгүй болно. Татгалзал нь түүнийг баталгаажуулж буй Тал бичгээр гаргаагүй тохиолдолд нь хүчингүй байна.

39. Нэмэлт баталгаа

Тал тус бүр Гэрээний заалтуудыг болон төлөвлөгдсөн хэлцлүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай эсхүл хэрэгцээтэй байж болох бүхий л зүйлсийг хийх буюу акт, тоног төхөөрөмж, шилжүүлэг болон бусад баримт бичиг зэргийг үйлдэхийг хүлээн зөвшөөрөв.

40. Гэрээний тусгаар байдал

40.1 Гэрээний тусгаар байдал

Аль ч эрх зүйн тогтолцооны хувьд хориглосон эсхүл хэрэгжих боломжгүй гэрээний аливаа заалт нь тухайн эрх зүйн тогтолцоонд хориглосон эсхүл хэрэгжих боломжгүй хэмжээгээр хүчингүй байна. Энэ нь тухайн Гэрээний бусад үлдсэн заалтуудыг хүчингүй болгохгүй бөгөөд аль ч эрх зүйн тогтолцооны хувьд тэдгээрийн хүчин төгөлдөр, хэрэгжих боломжийг хөндөхгүй болно.

40.2 Сайн санаагаар хэлэлцээ хийх

Гэрээний заалт нь хориглогдсон эсхүл хэрэгжих боломжгүй байгаа тохиолдолд Талууд тухайн хүчин төгөлдөр бус заалтыг хэрэглэгдэх хууль тогтоомжид нийцсэн, талуудын анхны хүсэл сонирхолд аль болох ойр байх заалтаар солих тухай хэлэлцээг итгэлцлийн журмаар хийх шаардлагатай бөгөөд гэрээнд зохих нэмэлт өөрчлөлтийг (хэрэв байгаа бол) оруулна.

41. Удирдлага болгох хууль

41.1 Удирдлага болгох хууль

Энэхүү Гэрээ, түүнтэй холбогдон гарах гэрээний бус үүрэг болон Гэрээнд хавсаргасан арбитрын гэрээнд Англи ба Уэльсийн хууль тогтоомжийг удирдлага болгоно. Талууд Сингапур улсын эрх зүйн тогтолцоонд үйлчилж буй аль Шүүхийн онцгой бус харьяалалд нэхэмжлэл гаргана.

41.2 НҮБ-ийн конвенц – Олон улсын бараа худалдах, худалдан авах

НҮБ-ийн Олон улсын бараа худалдах, худалдан авах хэлэлцээрийн конвенц болон бусад төсөөтэй хэрэглэгдэх хуулийг энд Хэрэглэгдэх хуулиудын зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээгээр татгалзаж байгаа болно.

41.3 Гуравдагч талын эрх

Рио Тинто группийн гишүүд эсхүл нөхөн төлбөрийн нөхцөлийн дагуу нэхэмжлэх гаргаж буй Компанийн ажилтантай холбоотойгоос бусад тохиолдолд Гэрээний тал биш аливаа этгээд нь Гэрээний (Гуравдагч талын эрх) тухай 1999 оны хуулийн дагуу ямарваа нэгэн эрхгүй байна.

42. Гэрээний нөхцөлийн хүчинтэй байдал

- (a) Дараахь зүйлүүд нь гэрээ дуусгавар болох эсхүл цуцлагдсан ч хүчинтэй хэвээр байна. Үүнд: 5 (Үйлчилгээ үзүүлэгчийн баталгаа), 11 (Татвар), 14 (Төлбөрөөс хасаж тооцох), 25 (Даатгал), 26 (Нөхөн төлбөр), 29 (Маргаан шийдвэрлэх), 30 (Нууцлал), 32 (Оюуны өмчийн эрх) болон 37 (Хувийн мэдээлэл ба мэдээлэл хамгаалал) зүйлүүд.
- (b) Энэхүү гэрээн дэх нөхөн төлбөр бүр нь Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үүргээс тусдаа, бие даасан үргэлжилсэн үүрэг бөгөөд Гэрээг цуцлах эсхүл дуусгавар болсон ч хүчинтэй хэвээр байна.

43. Гэрээний хэл

Энэхүү Гэрээг Англи хэл дээр боловсруулсан бөгөөд аливаа орчуулгыг Англи хэлнээс хийсэн болно. Гэрээний агуулга, утга санаа болон тайлбарын талаар аливаа зөрчилдөөн эсхүл асуулт гарсан тохиолдолд Англи хэл дээрх заалтууд давамгайлна.